МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК
Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71
Цахим хуудас: www.mongolbank.mn

2024.12.04 № А-1/911
танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Г.ОЧИРБАТ ТАНАА

Тогтоолын хэрэгжилтийн талаарх
асуулгын хариу хүргүүлэх тухай

Танаас 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 24 дугаар тоот албан бичгээр ирүүлсэн тогтоолын хэрэгжилтийн талаарх асуулгын хариуг хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор "Зээлийн хүүг бууруулах стратеги"-ийг баталж, хэрэгжилтийг хангахыг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус даалгасан билээ. Тус стратегийг баталж хэрэгжүүлж эхэлснээс хойш зээлийн хүү алгуур буурч, банкнуудын тухайн сард шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2021 оны эцэст 14.3 хувьд, төсөл, хөтөлбөрийн зээлийг оруулсан төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 13.2 хувьд тус тус хүрсэн (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Тухайн сард шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү бууруулах стратегид туссан арга хэмжээнүүд хэрэгжиж, тодорхой үр дүнд хүрсэн боловч, нийгмийн эрүүл мэнд, олон улсын харилцааны дараалсан томоохон шокууд нь эдийн засгийн хүндрэлийг дагуулж, санхүүгийн зах зээлийн суурь хүүг нэмэгдүүлэхэд хүргэсэн нь зээлийн хүүг үргэлжлүүлэн бууруулах бус өсгөх нөхцөлийг бий болгосон юм. Тодруулбал, Монгол Улсын 2019 оны нөхцөл байдлыг авч үзвэл инфляц улсын хэмжээнд 5.2 хувьд хүрсэн, бодит эдийн засаг 5.6 хувиар өсөж эдийн засгийн үйл ажиллагаа сайжирсан, макро эдийн засгийн орчин тогтворжсон, сэргэлт үргэлжилсэн жил байв. Харин 2020 оны эхнээс Монгол Улс цар тахлын хүндрэлтэй нүүр тулгарч, тус эрсдэл нь геополитикийн хурцадмал нөхцөл байдлаар даамжирсан нь бизнесийн үйл ажиллагааны доголдол, өртөг зардал нэмэгдэхэд нөлөөлж, дотоод

1524023322

эдийн засагт үнийн дарамт учруулсан. Худалдааны гол түнш улс болох БНХАУ-ын "Тэг-Ковид" бодлого 2022 оныг дуустал үргэлжилсэн нь хилийн хаалттай байдлыг бий болгож, олон улсын тээвэр, логистик, нийлүүлэлтийн доголдлыг даамжруулсан.

Тээврийн зардал, худалдааны түнш орнуудын инфляц, гадаад үнэ зэрэгтэй холбоотой гадаад шалтгаантай инфляцын дарамт огцом нэмэгдэж, инфляц 2022 оны 6 дугаар сард 16.1 хувьд хүрсэн нь сүүлийн 10 жилийн хамгийн өндөр түвшин болсон. Ийнхүү Монгол Улс төдийгүй дэлхийн бүх улс орнууд өндөр инфляцын давлагаатай нүүр тулж, санхүүгийн зах зээлийн суурь хүү 2020 оны 0.25 хувийн түвшнээс 2023 оны 6 дугаар сард 5.5 хувь хүртэл өссөн нь гадаад санхүүжилтийн өртөг нэмэгдэх, улсын эрсдэлийн үнэ өндөр байх, цаашлаад зээлийн эрсдэлийн зардал, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зардал нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж, банкнуудын зээлийн хүү буурахгүй байх нөхцөл болсон. Дэлхий дахинд ам.долларын суурь хүү 5 гаруй нэгж хувиар нэмэгдсэн нь хүүний тэнцвэрийг хангахын тулд бусад валютуудын хүү мөн ойролцоо хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагыг бий болгосон. Тухайн эдийн засгийн суурь хүү өсөх нь санхүүгийн зах зээл дэх бусад хүүнүүдийн өсөлтийн шалтгаан болсон.

Дотоод орчин талаас 2023 оны эхнээс гадаад эдийн засгийн нөхцөл байдал сайжрахтай зэрэгцээд төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмжийг удаа дараа нэмж, төсвийн зардал тогтмол тэлсэн нь эрэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг нэмэгдүүлж, улмаар бодлогын хүү өсөх, бодлогын хүү буурах орон зайг хязгаарласан.

Банкны зээлийн хүү буурах нэг хөшүүрэг нь зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг, маргааныг зардал багатай хянан шийдвэрлэх чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох явдал юм. Тус ажлын хүрээнд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Монголбанк, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Монголын Банкны Холбооны төлөөллийг оролцуулан байгуулж, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Гэвч эдгээр хуулийн төсөл УИХ-д өргөн баригдаагүйгээс гадна Хууль тогтоомжийн тухай хуулийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36.1 дэх хэсэгт заасан хууль санаачлах хүрээ хязгаарын хүрээнд зээлийн хүү бууруулахад ач холбогдол бүхий хэрэг, маргаан хянан шийдвэрлэх процессын хуулийн төслийг Засгийн газар санаачлах зохицуулалттай байна. Ийнхүү гадаад, дотоод орчны гэнэтийн эрсдэл, тодорхой бус байдал болон холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой хязгаарлалтууд нь Зээлийн хүү бууруулах стратегийн хэрэгжилт удаашрахад нөлөөлж байна. Тус стратегид туссан боловч хэрэгжилт удаашралтай байгаа дээрх хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудалд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах хүсэлтийг үүгээр уламжилж байгааг хүлээн авна уу.

Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолд заасны дагуу "Зээлийн хүүг бууруулах стратеги"-ийн хэрэгжилтийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд хагас жил тутам танилцуулдаг бөгөөд таны ирүүлсэн асуулгын хүрээнд "Зээлийн хүүг бууруулах стратеги"-ийн 2024 оны 3 дугаар улирлын байдлаарх хэрэгжилтийн мэдээллийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 93 хуудас.

ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН

Монголбанкны 2024 оны 12 дугаар сарын 04-өдрийн
А-1/911 дугаартай албан бичгийн нэгдүгээр хавсралт

ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/2024 оны 3 дугаар улирлын байдлаар/

Д/д	Чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Дэд арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт
1	**Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх**	1.1.Төсвийн тогтвортой байдал, сахилга батыг хангах, эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлэх	1.1.1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн хэмжээг баримтлах	**Засгийн газар** Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн хэмжээг баримтлах	2020-2021	**<u>Засгийн газар</u>** Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримталж, тэдгээрийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Засгийн газрын 2006 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан. "Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам"-ыг 2021 оны 07 сарын 21-ний өдрийн 211 дүгээр тогтоолоор шинэчлэн батлуулсан. Дээрх шинэчлэн батлуулсан журмаар гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг үнэлэх, төслийн хэрэгжилтэд хяналт тавих болон өр төлбөрийг бүртгэх механизмуудыг сайжруулан тусгасан байна. Үүний үр дүнд төслийн эрсдэлийг үнэлж, илүү нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой төслийг санхүүжүүлж, өргөн төлөлтийг сайжруулах боломж бүрдсэн. Засгийн газрын зүгээс баталгаанаас үүсэх болзошгүй өр төлбөрийг багасгах, Засгийн газрын өрийн Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг бууруулах зорилгын хүрээнд өрийн баталгаа нэмж гаргахгүй байх бодлогыг хэрэгжүүлсээр байна. Түүнчлэн Засгийн газрын өрийн баталгаатай холбоотой харилцааг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 146 дугаар тогтоол, Сангийн сайдын 2015 оны 94 дүгээр тушаалаар батлсан журмаар

						зохицуулж байсныг нэгтгэн, нэг эрх зүйн актаар зохицуулах нь Өрийн удирдлагын тухай хуулийн 35.6, 35.10-т нийцэж байсан тул "Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавигдах шаардлага, авлага барагдуулах журам"-ыг 2021 оны 07 сарын 21-ний өдрийн 210 дүгээр тогтоолоор шинэчлэн батлуулсан. Дараах журмын зохицуулалтыг нэгтгэж шинэчилснээр Засгийн газрын баталгаа бүхий төсөл, арга хэмжээнд жил бүр эрсдэлийн үнэлгээ хийх, баталгаа гаргуулагчийн хувьд үүсэж болох байгууллагын эрсдэлээс сэргийлэх зэрэг өөрчлөлтийг хийсэн. Олон улсын санхүүгийн байгууллагууд хамтран Монгол Улсын Засгийн газрын өрийн удирдлагын 2008-2016 онуудын гүйцэтгэлд үнэлгээ хийсэн бөгөөд тухай үед Монгол Улс "хангалтгүй" үнэлэгдэж байсан. Үүний дагуу Сангийн яамны зүгээс өрийн удирдлагын тогтолцооны болон гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулах бодлогын баримтлан ажилласнаар 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр төсвийн алдагдлын хэмжээ 1 их наяд төгрөг буюу ДНБ-ний 1.9 хувьтай тэнцэж, Засгийн газрын өрийн үлдэгдэл 31.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 26.9 их наяд төгрөгтэй, ДНБ-ий 52.4 хувьтай тэнцэж байгаа нь 70 хувиас хэтрэхгүй байхаар заасан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн Засгийн газрын өрийн тусгай шаардлагад нийцэж байна.
			1.1.2.Гадаад валютын орох урсгалыг дэмжиж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлэх	**Засгийн газар, Монголбанк** Монгол Улсын Засгийн газраас олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудтай уулзалт зохион байгуулах Монголбанкны зүгээс банк санхүү, эдийн засаг болон	2020-2021	**<u>Монголбанк</u>** 2022 онд Зээлжих зэрэглэлийн агентлагууд болон Монгол Улсын хамтарсан уулзалтуудыг цахим болон биет хэлбэрээр зохион байгуулж, зээлжих зэрэглэлийн үнэлгээний тайланг удирдлагуудад танилцуулсан. Харин зээлжих зэрэглэлийн үнэлгээ гарсантай холбоотойгоор хөрөнгө оруулагчдыг манай улсад санхүүжилт олгох сонирхлыг нэмэгдүүлэх хүрээнд Монголбанк болон

				холбогдох бодлогын шийдвэрийн талаар мэдээллээр хангаж, дэмжиж ажиллах.		Сангийн яам, холбогдох байгууллагууд хамтран шаардлагатай уулзалтыг амжилттай зохион байгууллаа. 2022 онд Фитч болон Эс энд Пи агентлагуудтай цахим уулзалт зохион байгуулсан бол Мүүдиз агентлагтай биечлэн уулзалт зохион байгууллаа. Эдгээр уулзалтаар Монголбанкны төлөөллүүдийн зүгээс эдийн засгийн төлөв болон банкны системийн нөхцөл байдлын талаар сүүлийн үеийн мэдээллийг хуваалцсан. Улмаар, 2022 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр Мүүдиз агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "B3", төлөвийг "тогтвортой" хэвээр үлдээсэн. Харин 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Фитч агентлаг, 2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Эс энд Пи агентлаг тус бүр Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "B", төлөвийг мөн "тогтвортой" хэвээр үлдээсэн. 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр МУ-ын Засгийн газар 5 жилийн хугацаатай, 8.65 хувийн хүүтэй, 650 сая ам.долларын "Century 2" бондыг олон улсын зах зээл дээр амжилттай гаргахад Засгийн газартай хамтран ажиллалаа. Олон улсын валютын сан, Дэлхийн банкны жилийн уулзалтын үеэр буюу 2022 оны 10-р сард АНУ дахь хөрөнгө оруулагч нартай биечлэн уулзаж, тухайн үед хөрөнгө оруулагчидын дунд үүссэн нөхцөл байдлыг шийдвэрлэв. 2023 он гарснаас хойш олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч болон Эс энд Пи агентлагуудтай уулзалтуудыг зохион байгууллаа. Тодруулбал, 2023 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Фитч агентлагтай, 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Эс энд Пи агентлагтай Монголбанкны удирдлагууд уулзаж, банк санхүү, эдийн засаг болон холбогдох бодлогын шийдвэрийн талаарх мэдээллүүдийг өгөв. Улмаар 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "B", төлөвийг "Тогтвортой" хэвээр
			1.1.3.Олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагчтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх	**Засгийн газар, Монголбанк** Монгол Улсын Засгийн газраас олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудтай уулзалт зохион байгуулах Монголбанкны зүгээс банк санхүү, эдийн засаг болон холбогдох бодлогын шийдвэрийн талаар мэдээллээр хангаж, дэмжиж ажиллах.	2020-2021	

						үлдээсэн, 2023 оны 7 дугаар сарын 27-ны өдөр Эс энд Пи агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "B", төлөвийг "Тогтвортой" хэвээр үлдээснийг тус тус зарласан. 2024 оны 8 дугаар сар болон 9 дүгээр сард Монголбанкны удирдлагууд Эс энд Пи болон Фитч агентлагуудтай биечлэн уулзалтуудыг хийв. Улмаар Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 9 дүгээр сарын 18-ны өдөр Фитч агентлаг "B+" болгон, 10 дугаар сарын 4-ний өдөр Эс энд Пи агентлаг "B+", төлөвийг "Эерэг" болгон нэмэгдүүлснээ тус тус зарлав. Зээлжих зэрэглэлийг ахиулахад Монгол Улсын эдийн засгийн өсөлт хүлээлтээс давж, цаашдын өсөлтийн төлөв сайн байгаа, нүүрс зэсийн импортын өсөлтийг даган гадаад секторын болон төсвийн үзүүлэлтүүд сайжирсан, гадаад валютын нөөц нэмэгдэхийн зэрэгцээ гадаад өрийн түвшин буурч, эргэн төлөлтийн хуваарь илүү уян хатан болсон зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна.
		1.2.Экспорт, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжин гадаад валютын нөөцийг нэмэгдүүлж, гадаад эх үүсвэрийн өртгийг бууруулах	1.2.1.Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас бага хүүтэй экспортын санхүүжилт бүрдүүлэх	**Засгийн газар** Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас бага хүүтэй экспортын санхүүжилт бүрдүүлэх	2020-2024	**Засгийн газар** Уул уурхайн бус салбарын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилгоор Дэлхийн банкны санхүүжилтээр "Экспортыг дэмжих" төслийг хэрэгжүүлж дууссан. Нийт 131 аж ахуйн нэгжид 19 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн гэрээ байгуулж, 14.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон, экспортын бодлого зохицуулалт, хууль эрхзүйн орчныг сайжруулах чиглэлээр 25 судалгааны ажил хийгдэж дууссан. Мөн НҮБ-АҮХБ-тай байгуулсан зөвлөх үйлчилгээний хүрээнд Монгол Улсын магадлан итгэмжлэл, чанарын удирдлагыг сайжруулах ажил хэрэгжиж дууссан. Төслөөс хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудад хамрагдсанаар 31 компани шинээр экспортонд бараа бүтээгдэхүүнээ гаргаж эхэлсэн ба

						төслийн үр шим хүртэгчдийн экспортын өсөлт 58,4 сая ам доллар болж, суурь онтой харьцуулахад 81 хувь өссөн. Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банк эдийн засаг, дотоодын нийт бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын өсөлтөөс хамааран Монгол Улсад олгодог байсан нэн хөнгөлөлттэй эх үүсвэрийг бууруулж, хувьсах хүүтэй зээлийн эх үүсвэрийг санал болгодог болсон. Хувьсах хүүтэй энгийн эх үүсвэрийн хувьд зах зээлийн нөхцөл байдлаас хамааран ихээхэн өөрчлөгддөг бөгөөд КОВИД-19 цар тахал болон Орос, Украйны мөргөлдөөнөөс хамааран 2021 онд 0.16 хувьтай байсан хүү 2023 оны байдлаар 5.3 хувь болтлоо өссөн. Мөн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 2022, 2023 онуудад 300.0 сая ам.долларын төсвийн дэмжлэгийг Азийн хөгжлийн банкнаас зээллэг хийсэн болно.
				Монголбанк Олон улсын байгууллагуудтай үүсмэл хэрэгсэл байгуулж, өртөг багатай, төгрөгийн санхүүжилт олгох нөхцөлийг бүрдүүлэх.		**Монголбанк** Олон улсын байгууллагаас бага хүүтэй, урт хугацаат эх үүсвэр татахад шаардлагатай “Банк хоорондын валютын үүсмэл хэрэгслийн ерөнхий гэрээ” (ISDA)-г ОУ-ын байгууллага болох Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банк (EBRD)-тай 2021 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр байгуулсан бөгөөд гэрээний хүрээнд 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 11.9 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийг байгуулаад байна. Тус эх үүсвэрээр EBRD нь өртөг багатай төгрөгийн санхүүжилтийг дотоодын ААН-үүдэд олгох юм.
			1.2.2.Засгийн газрын “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, Монголбанкинд алт тушаалтыг нэмэгдүүлэх	**Монголбанк** Алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй хүүтэй санхүүжилт олгож, эргэн төлөлтөд хяналт тавих.	2020-2021	**Монголбанк** 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 100.1 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн, 405.3 тэрбум төгрөгийн урт хугацаат санхүүжилтийн, нийт 505.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 27 ААНБ-т олгосон. Энэхүү санхүүжилтүүд хуваарийн дагуу эргэн төлөгдөж, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар

				Аж ахуйн нэгжүүдээс алт худалдан авалтыг нэмэгдүүлэх.		санхүүжилтийн үлдэгдэл дүн 6.4 тэрбум төгрөг болоод байна.
			1.2.3.Гадаад валютын улсын нөөцийн удирдлагыг сайжруулах	**Монголбанк** Алтны урьдчилгаа санхүүжилтийн хүрээнд гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас хямд эх үүсвэр бүрдүүлэх.	2020-2021	**Монголбанк** Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, Алт-2 үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолыг үндэслэн 2020 оны 6 дугаар сараас 2022 оны 12 дугаар сарыг дуустал алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхээр арилжааны банкаар дамжуулан алтны урьдчилгаа санхүүжилтийн эх үүсвэрийг олгож эхэлсэн. Тус санхүүжилтийн хүрээнд шаардлагатай хямд эх үүсвэрийн гэрээг гадаадын банк санхүүгийн байгууллагатай амжилттай байгуулан ГВУН-ийг нэмэгдүүлж ажилласан бөгөөд гэрээнд заасан хугацаанд гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн.
			1.2.4.Экспортын бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, өртгийг бууруулах дэд бүтцийг байгуулах ажлыг хувийн хэвшилд түшиглэн эрчимжүүлэх	**Засгийн газар** Экспортын бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, өртгийг бууруулах дэд бүтцийг байгуулах ажлыг хувийн хэвшилд түшиглэн эрчимжүүлэх	2020-2024	**Засгийн газар** Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт Сангийн сайдын багцад Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2019 оноос эхлэн хилийн Замын-Үүд, Гашуунсухайт боомтын шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлж байна. Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслөөс Төлбөрийн №7 гүйцэтгэлээр 18,016,089 юанийг 2023 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 738 тоот албан бичгээр БНХАУ-ын IPPR олон улсын инженеринг ХХК-д хүргүүлсэн 2024

						оны 04 дүгээр сарын 24-ны өдөр гүйцэтгэгчийн дансанд орсон гэж мэдэгдсэн байна. БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2019 оноос эхлэн хилийн Замын-Үүд, Гашуунсухайт боомтын шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлж байна. 2024 онд 27.5 тэрбум төгрөгийг тусламжийн хөрөнгөөс зарцуулахаар төлөвлөснөөс 8.4 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж 31 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Төслийн нийт санхүүжилтийн гүйцэтгэл 86% буюу 121.9 тэрбум төгрөг байна. Үлдэгдэл санхүүжилт ажил бүрэн дууссахаар гүйцэтгэл батгаажуулан санхүүжилтийн хүсэлтийг хүргүүлнэ. Үүнээс Замын-Үүд боомтын Зорчигч тээврийн цогцолборын нийт 21 нэрийн барилга байгууламж, авто зам талбай, ИШС-ний БУА-ыг дуусгаж 2023.01.17-ны №УКД01/2023 дугаар дүгнэлт, Ачаа тээврийн цогцолборын нийт 19 нэрийн барилга байгууламж, авто зам талбай, ИШС-ний БУА-ыг дуусгаж 2023.11.03-ны №УКД31/2023 дугаар дүгнэлтээр тус тус ашиглалтад оруулсан. Гашуунсухайт боомтын барилга байгууламж, авто зам талбай, инженерийн шугам сүлжээний ажлыг дуусгаж 2023.11.03-ны №УКД31/2023 дугаар дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Хайрхан багийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ажил 86.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн энэ төслийн хүрээнд Монгол талын хөрөнгөөр Замын Үүд боомтын цогцолборын нийт барилга угсралтын ажил 2019-2024 оны байдлаар 97.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 18 нэрийн ажлыг ашиглалтад хүлээлгэн өгч, 6 барилгын ажлын комисс ажиллуулахаар хүлээгдэж байна. Харин Гашуунсухайт боомтын нийт барилга угсралтын ажил 74.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Хайрхан багийн барилга байгууламжийн ажлын 3 гэрээ байгуулах ажил хийгдэж, 2 ажлын тендер шалгаруулалт явагдаж байна. Мөн Сангийн сайдын багцын "Тоног

						төхөөрөмж /улсын хэмжээнд/ батлагдсан Гашуунсухайт хилийн боомтын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх тоног төхөөрөмж худалдан авах угсарч суурилуулах ажлын тендер шалгаруулалт явагдаж байна. Төслийн хүрээнд хилийн Хавирга, Ханх, Шивээхүрэн, Цагааннуур боомтын ТЭЗҮ, БОТБҮ, нарийвчилсан зураг төслийн ажил иж бүрэн дуусаж, Захиалагч хүлээн авч Хилийн боомтын захиргаанд хүлээлгэн өгсөн. Бургастай, Ханги, Булган, Ульхан, Баянхошуу, Сүмбэр боомтын ТЭЗҮ, БОҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил дуусаж, 2 боомт хүлээлцэх шатандаа. 4 боомтын магадлалын нэгдсэн дүгнэлт гарахаар хүлээгдэж байна.

		1.3.Инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулж, дотоод эх үүсвэрийн өртгийг бууруулах	1.3.1.Инфляцыг зорилтот түвшин /6 хувь орчим/-д хадгалах	**Монголбанк** Инфляцын төсөөлөл, макро эдийн засгийн ирээдүйн төлөв, инфляцын зорилт болон бодлогын хувилбарууд бүхий бодлогын саналыг боловсруулж, улирал Мөнгөний бодлогын хороонд танилцуулах. Эрэлтийн шалтгаантай инфляцыг тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжүүлэх.	2020-2024	**<u>Монголбанк</u>** Инфляцын төсөөлөл, макро эдийн засгийн ирээдүйн төлөв, инфляцын зорилт болон бодлогын хувилбарууд бүхий бодлогын саналыг боловсруулж, улирал бүр Мөнгөний бодлогын хороо (МБХ)-нд танилцуулж байна. Түүнчлэн, эдийн засгийн нөхцөл байдал хурдан өөрчлөгдөж байгаатай уялдуулан шаардлагатай тохиолдолд ээлжит бусаар хурал зохион байгуулж төсөөлөл шинжилгээг шинэчлэн боловсруулж байна. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2020 онд ээлжит 4 удаа, ээлжит бусаар 3 удаа хуралдаж бодлогын хүүг нийт 5 нэгж хувиар бууруулан 6 хувь буюу түүхэн доод түвшинд хүргэн 2021 онд нийт 4 удаагийн ээлжит хурлаар бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах шийдвэрийг гаргасан. Ийнхүү 2020, 2021 онуудад бодлогын хүүг бага түвшинд хадгалсан нь зээлийн хүү буурах, цар тахлын үеийн эдийн засгийг дэмжих нэг суурь нөхцөлийг бүрдүүлсэн болно. 2022 онд цар тахлын тархалт намжиж, нийлүүлэлтийн доголдол арилан үнийн өсөлт саарах хүлээлттэй байсан хэдий ч ОХУ-Украины нөхцөл байдлын улмаас дэлхий нийтээр үнийн түвшин эрчимжиж, тээвэр логистикийн хүндрэл үргэлжилж, гадаад шалтгаантай инфляцын дарамт огцом нэмэгдсэний зэрэгцээ гадаад суурь хүү хурдтай өсөж, төгрөгийн өгөөжийг хадгалах шаардлагыг нэмэгдүүлсэн. Иймд МБХ 2022 онд ээлжит 4 удаа, ээлжит бусаар 1 удаа хуралдаж, дунд хугацаанд инфляцын хүлээлтийг тогтворжуулах, төгрөгийн өгөөжийг өсгөх, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг зохистой түвшинд хадгалах зорилгоор бодлогын хүүг нийт 7 нэгж хувиар нэмэгдүүлээд байна. 2023 оны эхний саруудад нийлүүлэлтийн шалтгаантай хүчин зүйлсийн нөлөө саарч, инфляц төсөөлөлтэй нийцтэйгээр алгуур буурах хандлага үргэлжилж байсан хэдий ч 2 дугаар улиралд мах, махан бүтээгдэхүүний үнэ хурдтай өссөний зэрэгцээ импортын барааны үнэ буурах

				Мөнгөний бодлогын талаар олон нийттэй харилцах харилцааг өргөжүүлэх.		хурд хүлээлтээс удаан байгаа зэргээс шалтгаалан инфляцын төсөөлөл нэмэгдлээ. Түүнчлэн, төсвийн тодотголоор цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зардлууд нэмэгдэж батлагдсан нь эрэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг өсгөх эрсдэлтэй байв. Ийнхүү гадаад эрсдэл, тодорхой бус байдал өндөр хэвээр, төсвийн зардал тэлж, эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт нэмэгдэх хүлээлттэй зэргийг харгалзан МБХ инфляцыг зорилтот түвшний орчимд тогтворжуулах, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах, төгрөгийн өгөөжийг хадгалах зорилгоор 2023 оны туршид бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэрийг гаргав. Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн хатуу мөнгөний бодлого үр дүнгээ өгч инфляц 2023 оны сүүлээс зорилтот түвшинд ирж тогтворжлоо. Түүнчлэн, худалдааны түнш орнуудын инфляц саарч, төгрөгийн ханш бусад валютуудын эсрэг чангарсан зэрэг нь инфляц буурахад нөлөөлөв. Харин өвөлжилт хүндэрсний улмаас хөдөө аж ахуйн салбар агших, цаашлаад нийт эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх хүлээлттэй болсныг харгалзан зээлийн нөхцлийг сулруулах, дунд хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих зорилгоор Мөнгөний бодлогын хороо 2024 онд ээлжит 2, ээлжит бус 1 удаагийн хурлаар бодлогын хүүг шат дараатайгаар бууруулж, 10 хувьд хүргэлээ. Энэхүү шийдвэр нь инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд тогтворжуулах, эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилттой нийцтэй болно. Инфляц 2024 оны 9 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 6.7 хувь, Улаанбаатар хотод 6.5 хувьтай байна. Импортын бараа, бүтээгдэхүүний инфляц саарах хандлага үргэлжилсний зэрэгцээ дотоодын хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт тогтворжсон нь инфляц ийнхүү буурахад нөлөөллөө. Гэхдээ нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамт бүрэн арилаагүй үед төсвийн зардал эрчтэй нэмэгдэж байгаа нь

						эрэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг нэмэгдүүлэх өндөр эрсдэлтэй байна. Цаашид эдийн засгийн сэргэлт, инфляцын өрнөл, нийлүүлэлтийн шинжтэй доголдол, олон улсын харилцааны нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарч мөнгөний бодлогын дараагийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Мөнгөний бодлогын хорооны хурлын шийдвэрүүдийг тухай бүр хэвлэлийн бага хурлаар танилцуулж, мөнгөний бодлогын мэдэгдэл болон инфляцын тайлан Монголбанкны цахим хуудсанд байршуулсны зэрэгцээ хурлын хураангуй тэмдэглэлийг хурлаас хоёр долоо хоногийн дараа цахим хуудсанд байршуулан Төв банкны нээлттэй, ил тод байдлыг ханган ажиллаж байна. Түүнчлэн инфляцын түвшин зорилтот түвшнээс давах тохиолдолд Монголбанкнаас холбогдох тайлбарыг олон нийтэд хүргэн ажиллаж байна.

			1.3.2.Нийлүүлэлтийн шалтгаантай инфляцыг бууруулахад чиглэсэн дэд бүтцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх	**Засгийн газар**	2020-2024	**Засгийн газар** Засгийн газар Нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамт үүсгэдэг бүтээгдэхүүн болох хүнсний ногооны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор усалгаатай газар тариаланг дэмжихээр АХБ-ны зээл, буцалтгүй тусламж (Ядуурлыг бууруулах Япон сан) болон төсвийн санхүүжилт (татварын чөлөөлөлт + мөнгөн бус оролцоо)-ээр 46.25 сая.ам долларын төсөвт өртөг бүхий төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд ургамал газар тариаланг,урийн 4 төвийн усалгааны 4 системийг сэргээн засварлахаар төлөвлөж,бэлтгэл ажлуудыг гүйцэтгэж байна.Төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Сагсай, Баяннуур,Завхан аймгийн Тэлмэн,Улиастай сум, Ховд аймгийн Алтай, Эрдэнэбүрэн сум,Говь-Алтай аймгийн Халиун,Жаргалан сум,Төв аймгийн Батсүмбэр сум, Сэлэнгэ аймгийн Сант сум, Хэнтий аймгийн Хэрлэн 11 сумын усалгааны системийг шинэчлэн сайжруулах ажлын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж дундаж дүнгээрээ эдгээр 11 сумын усалгааны системийн барилгын ажлын гүйцэтгэл 78 хувийн гүйцэтгэлтэй байна.
		1.4.Экспортын санхүүжилтийг	1.4.1.Уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн салбарын зээлдэгчид бага хүүтэй зээл олгох нөхцөлийг дараах байдлаар бүрдүүлэх: - Уг салбарт банкнаас олгосон хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах; - Зээлээр баталгаажсан үнэт цаастай холбоотой тусгай зөвшөөрөл олгох, үнэт цаасыг бүртгэх талаар	**Монголбанк** Эдийн засаг, санхүүгийн зах зээлд үзүүлэх боломжит нөлөөллийн талаарх тооцоо, судалгааг боловсруулсны үндсэн дээр Мөнгөний бодлогын хэрэгслээр олгох санхүүжилтийн хэмжээ, нөхцөлийг Мөнгөний бодлогын хороогоор шийдвэрлүүлэх.	2020-2021	**Монголбанк** • Мөнгөний бодлогын хэрэгсэлд өөрчлөлт оруулах боломжийг судалж, урт хугацаат репо санхүүжилтийн нөхцөлд өөрчлөлт оруулан Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 9 дүгээр сарын хуралдаанд танилцуулж, тус хэрэгслийг нэвтрүүлсэн. Ингэснээр Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос 2020 оны 4 дүгээр улиралд 230 тэрбум төгрөг, 2021 оны 1 дүгээр улиралд 250 тэрбум төгрөг, 2 дугаар улиралд 350 тэрбум төгрөг, 3 дугаар улиралд 250 тэрбум төгрөг, 4 дүгээр улиралд 100 тэрбум төгрөг, 2022 оны 1 дүгээр улиралд 250 тэрбум төгрөгийг банкуудад урт хугацаат репо арилжаагаар олгохоор шийдвэрлэсэн бөгөөд 2024 оныг дуустал 574.4 тэрбум төгрөгийг 3 жил

		нэмэгдүүлэхэд бодлогын хэрэгслийг ашиглах	холбогдох арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх; - Мөнгөний бодлогын хороогоор мөнгөний бодлогын хэрэгслээр олгох санхүүжилтийн хэмжээ, нөхцөлийг инфляц, ханш болон гадаад валютын нөөцөд үзүүлэх нөлөөллийг харгалзан тухай бүр нь хэлэлцэн шийдвэрлэсний үндсэн дээр баталгаажсан үнэт цаасыг барьцаалсан Төв банкны репо санхүүжилтийг 1-2 жилийн хугацаатай, бодлогын хүүтэй ойролцоо хүүтэй олгож эх үүсвэр бүрдүүлэх.			хүртэл хугацаатай ЖДҮ, уул уурхайн бус экспорт, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийг дэмжих чиглэлээр олгосон төгрөгийн хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаасаар репо арилжаа хийх шийдвэр гаргав. Үүнээс банкуудад 2020 онд 230.0 тэрбум төгрөг, 2021 онд 1,161.7 тэрбум төгрөг, 2022 онд 180.6 тэрбум төгрөг, 2024 онд эхний 9-н сарын байдлаар 248.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон бөгөөд нийт 1,821.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна. Ингэснээр банкууд 2021 онд 3,375 зээлдэгчдэд 825.5 тэрбум, 2022 онд 282 зээлдэгчдэд 483.3 тэрбум, 2023 онд 3.3 тэрбум төгрөгийн репо зээлийг олгосон бол 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 209 зээлдэгчид 50.9 тэрбум төгрөгийн репо зээлийг олгосон. Ингэснээр нийт 1,629.4 тэрбум төгрөгийн 4,636 зээлдэгчийн зээлийг дахин санхүүжүүлэх, болон шинээр санхүүжүүлэхээр судалснаас 73,550 ажилтантай, 3869 зээлдэгчийн 1,363.0 тэрбум төгрөгийн дүн бүхий гэрээг байгуулаад байна. • Уул уурхайн бус экспорт, ЖДҮ, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийг дэмжих чиглэлд олгох урт хугацаат репо арилжааны санхүүжилт дараах нөхцөлтэй байна. Үүнд: • Одоо байгаа уул уурхайн бус экспорт болон ЖДҮ салбарууд дээр үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, 200 болон түүнээс дээш ажилтантай бөөний болон жижиглэн худалдааны салбарыг хамруулах; • Зээлийн хүү нь репо арилжааны хүү+3 нэгж хувиас хэтрэхгүй байх; • Зээлийн хугацаа нь 2 жилээс доошгүй байх; • Зээлийн дээд хэмжээ Уул уурхайн бус экспортын салбарт хамтын санхүүжилт хэлбэрээр олгох зээлийн Монголбанкнаас олгох дээд хэмжээ 15.0 тэрбум төгрөг, банкны эх үүсвэр зээлийн нийт

						дүнгийн 30%-иас багагүй байх, бусад салбаруудад зээлийн дээд хэмжээ 3 тэрбум төгрөг хүртэл байх; • Харилцагчийн хүсэлтээр үндсэн төлбөрөөс 6-с доошгүй сараар чөлөөлөх. • Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө барьцаалах боломжтой байх. • Зээлийн төлбөрийг төлж барагдуулж чадахуйц бизнесийн үйл ажиллагаатай байх. • Монгол улсын хуулийн этгээд байх.
				Хэвийн ангилалд байгаа төгрөгийн зээлээр баталгаажсан үнэт цаасаар урт хугацаат репо арилжаа хийхэд бэлтгэл ажлыг хангах, арилжааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.		• Уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн салбарт олгосон төгрөгийн хэвийн зээлийг үнэт цаасжуулж, тухайн үнэт цаасыг Монголбанк репо арилжааны хэрэгслээр банкуудаас худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах юм. Үүнтэй холбоотой (1) Мөнгөний бодлогын хороонд танилцуулж, санал, зөвлөмж авах, (2) Тусгай зориулалтын компани (ТЗК)-ийг байгуулж, холбогдох зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос авах, (3) Эрх зүйн баримт бичгийг боловсруулж, өөрчлөлт оруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн, бэлтгэл ажлыг бүрэн хангасан. • Хэвийн зээлийг үнэт цаасжуулах ажлыг гүйцэтгэж буй “ҮЦСК актив нэг ТЗК” нь 40.5 тэрбум төгрөг (төлөгдөж дууссан), “ҮЦСК актив хоёр ТЗК” нь 160.4 тэрбум төгрөг, “ҮЦСК актив гурав ТЗК” нь 82.9 тэрбум, “ҮЦСК актив дөрөв ТЗК” нь 83.0, “ҮЦСК актив тав ТЗК” нь 35.7 тэрбум төгрөг, “ҮЦСК актив зургаа ТЗК” нь 30.3 тэрбум төгрөг нийт 432.8 тэрбум төгрөгийн үнэт цаасыг гаргалаа. Монголбанкнаас анх барьцаалсан үнэт цаасыг уг үнэт цаасаар солих ажлыг тухай бүрт нь зохион байгуулж ажиллаад байна.

				Санхүүгийн зохицуулах хороо "Монголын үнэт цаасны санхүүжилтийн корпораци" ХХК-ийн үүсгэн байгуулсан ТЗК бүрт тусгай зөвшөөрөл олгох, гаргасан үнэт цаасыг бүртгэх ажиллагааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хянаж, шуурхай шийдвэрлэн, хамтын ажиллагааны гэрээ байгуулах;		**<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны 2020 оны 882 дугаар тогтоолоор "Монголын актив удирдлагын корпораци" ХХК-д хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрлийг олгосон. Монголбанк (МБ)-ны мөнгөний бодлогын хорооны 2020.9.14-ний өдрийн хурлын 5 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт уул уурхайн бус экспортын салбарын болон жижиг, дунд үйлдвэрлэгчид олгосон төгрөгийн хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас барьцаалсан МБ-ны репо арилжааны хэмжээг 2020 оны 4 дүгээр улиралд 230.0 тэрбум төгрөгөөс илүүгүй байхаар тогтоосны дагуу "Монголын актив удирдлагын корпораци" ХХК нь /"Монголын үнэт цаасны санхүүжилтийн корпораци" ХХК /"МҮЦСК" ХХК/ гэж оноосон нэрээ өөрчилсөн. Уг "МҮЦСК" ХХК-д СЗХ-ны 2020 оны 937 дугаар тогтоолоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. СЗХ-ны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 2.1-т "Тусгай зориулалтын компани (ТЗК) нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6.1-д заасан тусгай зөвшөөрөл авснаас хойш 1 сарын дотор өөрийн гаргах баталгаат үнэт цаасыг Хороонд бүртгүүлнэ." гэж заасны дагуу "МҮЦСК" ХХК "ҮЦСК актив нэг ТЗК" ХХК-ны 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 3 хүртэл жилийн хугацаатай, уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн зээлээр баталгаажсан нийт 405,463 ширхэг хүртэлх баталгаат үнэт цаасыг СЗХ-ны 2021 оны 329 дүгээр тогтоолоор бүртгэсэн. Мөн уул уурхайн бус экспортын салбарын болон жижиг, дунд үйлдвэрлэгчид олгосон төгрөгийн хэвийн зээлээр баталгаажсан хоёр дахь удаагийн баталгаат үнэт цаас гаргах зөвшөөрлийг СЗХ-ны 2021 оны 579 дүгээр тогтоолоор "ҮЦСК актив хоёр" ХХК-д олгосон. СЗХ-ны 2021 оны 580 дугаар тогтоолоор"ҮЦСК актив хоёр" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 3 хүртэлх жилийн хугацаатай нийт 1,679,980

						ширхэг хүртэлх баталгаат үнэт цаасыг бүртгэсэн."ҮЦСК актив гурав ТЗК" ХХК-ийн гаргаж буй 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 15 хүртэлх жилийн хугацаатай, уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн зээлээр баталгаажсан нийт 2,176,350 ширхэг хүртэлх баталгаат үнэт цаасыг Хорооны 2022 оны 357 дугаар тогтоолоор бүртгэсэн. "ҮЦСК актив дөрөв ТЗК" ХХК-ийн гаргаж буй 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 8 хүртэлх жилийн хугацаатай, хөрөнгөөр баталгаажсан нийт 1,118,103 ширхэг хүртэлх баталгаат үнэт цаасыг Хорооны 2022 оны 451 дүгээр тогтоолоор бүртгэж зах зээлд тус тус гаргасан.
			1.4.2.Эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлын төлөвтэй уялдуулан төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг шат дараатай бууруулж, банкны салбараас олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх	**Монголбанк** Төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг эдийн засаг, банк, санхүүгийн тогтвортой байдал, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай уялдаж байгаа эсэхийг тооцож шаардлагатай тохиолдолд төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг өөрчлөх саналыг Мөнгөний бодлогын хороонд танилцуулж шийдвэрлүүлэх.	2020-2021	**Монголбанк** Төгрөгийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг эдийн засгийн өнөөгийн нөхцөл, банк, санхүүгийн тогтвортой байдал, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай уялдаж байгаа эсэхийг судалж, шаардлагатай тохиолдолд бодлогын арга хэмжээг авч ажилласан. Тодруулбал, банкны системд зээлийн тасалдал үүсэхээс сэргийлж, өрх, аж ахуй нэгжүүдийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор 2020 оны 11 дүгээр сарын Мөнгөний бодлогын хорооны хурлаар төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулж, 6 хувьд тогтоох шийдвэрийг гаргав. Түүнчлэн, банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулж, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгөд тооцох ЗБН-ийн хувь хэмжээг 3 нэгж хувиар нэмэгдүүлж, 18 хувьд хүргэв.

						Геополитикийн хүндрэл, худалдааны түнш орнуудын КОВИД-19-н эсрэг бодлого, тээвэр, логистикийн доголдол зэрэг нь инфляцын эрч нэмэгдэх нөхцөл болж энэ нь мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах шаардлагыг үүсгэсэн. Иймд Монголбанкны МБХ 2022 оны 1-р сарын ээлжит бус хурлаар төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 8 хувьд хүргэх шийдвэрийг гаргасан. Харин Монголбанкны МБХ 2024 оны 7-р сарын ээлжит хурлаар олон улсад эрсдэлгүй хүүгийн түвшин өндөр хэвээр хадгалагдаж, гадаад валютын ЗБН-ийн шаардлага өндөр байсан нь банкуудын эх үүсвэрийн зардлыг өсгөж байгаатай холбогдуулан банкуудын гадаад валютын ЗБН-ийн 3 нэгж хувиар бууруулж, 15 хувьд хүргэх шийдвэрийг гаргасан. Түүнчлэн Монголбанкны МБХ 2024 оны 9-р сарын ээлжит хурлаар Банкны салбарын зээлийн өсөлт эрчимжиж, хэрэглээний импортыг урамшуулах, дотоод эрэлтийг өдөөх, цаашлаад санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх зорилгоор төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээг 2 нэгж хувиар нэмэгдүүлэн 10 хувьд хүргэхээр шийдвэрлээд байна. Цаашид эдийн засаг, банк санхүүгийн тогтвортой байдал, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын нөхцөл байдал зэргийг харгалзан шаардлагатай тохиолдолд заавал байлгах нөөцийн хувь хэмжээг өөрчлөх саналыг МБХ танилцуулж шийдвэрлүүлэн ажиллана.
		1.5.1.Хөрвөх чадвартай хадгаламжийн сертификатыг бий болгох	**Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк** ҮЦЗЗТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөл болон ББЭБЭХЗҮАЭТ хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох санал	2020-2021	**<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсгийн түвшинд арилжааны банкны хадгаламжийн сертификатыг хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгох саналыг Монголбанкнаас боловсруулсан. Уг хуулийг УИХ-ын

		1.5.Санхүүгийн зах зээлд зээл, санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх		өгч, хууль санаачлагчтай хамтран ажиллах. Хөрвөх чадвар бүхий хадгаламжийн сертификатыг хөрөнгийн биржээр арилжах ажлыг зохион байгуулах.		хэлэлцүүлэгт бэлтгэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийн хүрээнд хөрвөх чадвартай хадгаламжийн сертификатыг бий болгох асуудлыг зарчмын хувьд дэмжиж, холбогдх саналаа өгсөн боловч санал дэмжигдээгүй батлагдсан. Улсын Их Хурлын 2024.05.16-ны өдрийн хуралдаанаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг эцэслэн баталсан. Тус хуульд хөрвөх чадвартай хадгаламжийн сертификатыг бий болгохтой холбоотой зохицуулалтыг шинээр нэмж тусгасан. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан СЗХ-ны даргын 2024.08.20-ны өдрийн 320 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн "Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам"-ын төсөл боловсруулан 2024.09.09-ний өдөр журмын төсөлд олон нийтээс санал авахаар СЗХ-ны цахим хуудаст байршуулсан. Журмын төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2024.09.27-ны өдөр зохион байгуулж, холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналуудыг журмын төсөлд тусгасан бөгөөд тус журмыг СЗХ-ны хуралдаанаар батлуулахаар ажиллаж байна. СЗХ-ны дарга, Сангийн сайдын 2024.04.08-ны өдрийн А/226/528 дугаар хамтарсан тушаалаар "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг СТОУС-д нийцүүлэн шинэчлэн баталлаа. Журамд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ нь арилжааны банкнаас гаргасан хадгаламжийн сертификатыг худалдан авч болох зохицуулалтыг тусгасан. **Монголбанк**

						УИХ-аас 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг батлагдсан бөгөөд хуулийн 19^{1} дүгээр зүйлийн $19^{1}.1$ дэх хэсэгт "Банкны тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй банк хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргаж болно" гэж; $19^{2}.1$ дэх хэсэгт "Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнахтай холбогдох журмыг Төв банк /Монголбанк/ болон Хадгаламжийн даатгалын корпорацийн саналыг харгалзан Хороо батална" гэж тус тус зохицуулсан. Үүний дагуу хадгаламжийн сертификатыг зах зээлд арилжих нарийвчилсан зохицуулалтыг боловсруулах чиг үүрэг бүхий Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбооны төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 320 тоот тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгээс "Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам"-ын төслийг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.

			1.5.2.Өртгийн сүлжээнд тулгуурласан санхүүжилтийн бүтээгдэхүүн бий болгох	**Монголбанк** ОУСК, Монголбанкны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх. -Өртгийн сүлжээний санхүүжилтийг банк санхүүгийн байгууллагууд, ЖДҮ эрхлэгч нарт танилцуулах хурал, арга хэмжээг ОУСК-тай хамтран зохион байгуулах, оролцох; **Санхүүгийн зохицуулах хороо** ОУСК, Санхүүгийн зохицуулах хорооны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах **Засгийн газар** **Монголын банкны холбоо** ОУСК тай хамтарсан Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн (НСС) зах зээлийг хөгжүүлэх төслийг шат дараатай хэрэгжүүлэх, холбогдох ажлын хэсгийг	2020-2024	**Монголбанк** • Факторингийн үйлчилгээ эрхэлдэг арилжааны банкуудын төлөөлөл, EuroChambar-ийн төлөөлөлтэй уулзалт хийж, тус үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай байгаа хууль эрх зүйн орчин, зохицуулалтын өөрчлөлтийн талаар саналыг нэгтгэв. • ОУСК, Монголбанк хамтран Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт (НСС)-ийг хөгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд "НСС-ийн аргачлал, техникүүдийн стандарт тодорхойлолтууд" гарын авлагыг монгол хэлнээ боловсруулж хэвлүүлэв. Уг гарын авлагыг Монголбанкны орон нутаг дахь салбарууд болон арилжааны банкуудын салбар, МҮХАҮТ-д хүргүүлээд байна. Мөн Монголбанк МҮХАҮТ, арилжааны банкуудын төлөөлөл болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран уул уурхайн бус экспортлогчидтэй цахим уулзалт зохион байгуулж Монголбанкны МБГ-аас нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн талаар илтгэлийг танилцуулав. • Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллүүд арилжааны зарим банкуудад НСС-ий бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломжийн талаар зөвлөгөө өгч, хамтарч ажиллах саналыг тавиад байна. Ингэхдээ Төв банкнаас ямар нэгэн хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэхгүй бөгөөд зөвлөмж, хэрэгжүүлэх арга мехазмын талаар дэмжиж ажиллах юм. • НСС-ийн системээр ноолуурын салбарын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр Монголбанкнаас МҮХАҮТ болон Ноос ноолуурын бизнес эрхлэгчдийн төлөөлөлтэй хамтран ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Мөн даатгалын систем болон олон улсын байгууллагуудын хөнгөлөлтэй зээлийн эх үүсвэрийг уул уурхайн бус экспорт, ялангуяа ноолуурын салбарт ашиглах, улмаар

				байгуулж, суурь судалгааг хийх		НСС-ийг илүү боловсронгуй бөгөөд өгөөжтэй болгох хүрээнд ажиллаж байна. • "Экспортлогч үндэстэн-шинэ сэргэлтийн бодлого" үндэсний чуулганыг Монголбанкнаас санаачлан МУЗГ, МҮХАҮТ-ай хамтран 2022 оны 10-р сарын 28-ы өдөр зохоин байгууллаа. Уг чуулганы үеэр НСС-ийн ач холбогдол, боломжуудын талаар мөн танилцууллаа. • Уул уурхайн бус экспортын гол бүтээгдэхүүн болох ноолуурын зах зээлд нийлүүлэлтийн сүлжээний боломжийг судлах хүрээнд 2023 онд Монголбанкны Мөнгөний бодлогын газрын эдийн засагч Б. Эрхэмбаяр, Н. Янжинлхам нарын "Монгол улсын ноолуурын салбарын төлөв байдал" сэдэвт судалгааны ажлыг боловсруулан Мөнгө, санхүү, баялаг сэтгүүлийн 34-р дугаарт хэвлүүлэв. Мөн тус судалгааны ажлыг холбогдох байгууллагууд, удирдлагуудад хүргүүлэв. • РЕПО санхүүжилтийн дүн: Зорилтот дүн болох 2,000 тэрбум төгрөгөөс 2020 онд 230.0 тэрбум төгрөг, 2021 онд 1,161.7 тэрбум төгрөг, 2022 онд 180.6 тэрбум төгрөг тус тус олгосон бөгөөд нийт 1,572.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. • Ипотекийн зээл: Зорилтот дүн болох 2,000 тэрбум төгрөгөөс 2021 онд 1,012.0 тэрбум төгрөг, 2022 онд 732.3 тэрбум төгрөг, 2023 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар 374.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийг нийт 24.7 мянган өрхөд олгоод байна. . **<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** - Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах, санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ болох ББСБ-уудын репо арилжаа, хадгаламжийн сертификат, итгэлцлийн үйлчилгээнд суурилсан санхүүгийн хэрэгслүүдийг арилжаалах мөнгөний захын платформын үйлчилгээ СЗХ-ны сэндбоксын орчинд 2 жилийн

						хугацаанд туршигдан, сэндбоксын орчноос гарах, зах зээлд нэвтрэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөл авсан 42 ББСБ нийт 411.9 тэрбум төгрөгийн хадгаламжийн сертификатад хөрөнгө оруулсан байна. Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-тай хамтран Монгол Улсад Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төслийг хамтран хэрэгжүүлэх "Харилцан ойлголцлын санамж бичиг"-т 2020.05.15-ны өдөр гарын үсэг үзэглэлээ. Энэхүү санамж бичгийн хүрээнд факторингийн үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль эрх зүйн зохицуулалт, нийцэл, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэхэд шаардагдах хүчин зүйлүүдийн талаар судалгаа дүгнэлт гарган улмаар "Авлага худалдан авалт буюу Факторингийн үйл ажиллагаа эрхлэх гарын авлага" боловсруулж, 531 ББСБ-д хүргүүлсэн ба 2023 оны 1 дүгээр сард дахин хэвлүүлж олон нийтийг сургалт, мэдээллээр хангасан. Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн ач холбогдлыг сурталчлах, санхүүгийн байгууллагуудын зээл олгох чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк, Шүүхийн ерөнхий зөвлөл, Монголын банкуудын холбоо зэрэг байгууллагуудтай хамтран 2020 оны 4 дүгээр улиралд "Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулагч байгууллагуудын гүйцэтгэх үүрэг" сэдэвт онлайн семинар, "Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн ач холбогдлыг сурталчлах, санхүүгийн байгууллагуудын зээл олгох чадварыг нэмэгдүүлэх" сэдэвт 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, зохицуулагч байгууллага

						болон аж ахуйн нэгжийн нийт 346 ажилтан, албан хаагчдыг хамруулсан. Түүнчлэн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд факторингийн компанийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тусгасан. Ийнхүү факторингийн үйл ажиллагааг зөвхөн авлага худалдан авах бус аж ахуйн нэгж байгууллагуудыг урьдчилгаа санхүүжилтийн эх үүсвэрийг санхүүжүүлснээр эдийн засгийг төрөлжүүлэх, гүнзгийрүүлэх, факторингийн компанийн хөгжлийг шинэ шатанд гаргах боломж бүрдэнэ. Мөн 2021.05.26-27-ны өдрүүдэд Олон улсын санхүүгийн корпорацтай хамтран факторингийн гарын авлагыг танилцуулах сургалтыг 35 ББСБ-д, 2021 оны 10 дугаар сард "Авлага худалдан авалт буюу факторингийн үйл ажиллагаа" цахим семинар, 2022.03.18-ны өдөр "Факторингийн гэрээг хэрхэн байгуулах" талаарх 105 оролцогчийг хамарсан вебинар уулзалтыг тус тус зохион байгуулсан. АХБ-наас хэрэгжүүлж буй TA 9654-MON: Бичил санхүүгийн салбарыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд Банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээний зохицуулалтын орчны суурь судалгааг хийж, журмын төслийг боловсруулсан. 2021 оны 11 дүгээр сард "Авлага худалдан авалт буюу факторингийн үйл ажиллагааны журам"-ын төслийг хянаж, Олон улсын санхүүгийн корпорацын холбогдох ажлын хэсэгт санал хүргүүлсэн. Үүний зэрэгцээ факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч, санхүүгийн байгууллага буюу гурван

						талыг холбосон эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг хангах технологид суурилсан цогц шийдэл бүхий "Cashme" цахим дундын платформыг банкны салбарт нэвтрүүлэх танилцуулгыг хийсэн. Факторингийн эрх зүйн орчныг бэхжүүлэх чиглэлээр "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн журам"-ын шинэчилсэн найруулгын төсөлд факторингийн үйл ажиллагаа эрхлэх этгээд болон үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлж, журмын төслийг СЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээг банк бус санхүүгийн байгууллагуудаас гадна нэр бүхий 2 арилжааны банк тусгай зөвшөөрлийн хүсэлт ирүүлснийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хянаж, СЗХ-ны 2023.01.25-ны өдрийн 34 дүгээр тогтоол, 2023.03.31-ний өдрийн 97 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон. ОУСК-с СЗХ болон бусад гол оролцогч талуудтай Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн (НСС) зах зээлийг хөгжүүлэх хамтын ажиллагааны хүрээнд НСС-тэй холбоотой шинээр хийгдэж буй ажлууд мөн тулгамдаж буй асуудлуудын талаар гол оролцогч талуудтай ярилцах, санал солилцох уулзалтыг 2024.05.16-ны өдөр зохион байгуулсан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 57 ББСБ, 2 арилжааны банк факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байх ба салбарын хэмжээнд 21.9 тэрбум төгрөгийн факторингийн тооцооны авлагын үлдэгдэлтэй байна.

						Засгийн газар. Засгийн газраас хэрэгжүүлж буй "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө"-ний хүрээнд ажлын байрыг дэмжих зээл, репо санхүүжилтийн зээлийг олгож байна. Энэхүү хүрээнд 2024 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар дараах гүйцэтгэлтэй байна. Үүнд: • Ажлын байрыг дэмжих зээл (ААН, иргэд): Зорилтын 2,000 тэрбум төгрөгөөс 1,952.6 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. • РЕПО санхүүжилтийн дүн: Зорилтот дүн болох 2,000 тэрбум төгрөгөөс 2020 онд 230.0 тэрбум төгрөг, 2021 онд 1,161.7 тэрбум төгрөг, 2022 онд 180.6 тэрбум төгрөг, 2024 онд эхний 9-н сарын байдлаар 248.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон бөгөөд нийт 1,821.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. • Ипотекийн зээл: Хөтөлберийн хүрээнд 2021 онд 1,012.0 тэрбум төгрөг, 2022 онд 732.2 тэрбум төгрөг, 2023 онд 932.4 тэрбум төгрөг, 2024 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар 1,105.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийг нийт 39.6 мянган өрхөд олгоод байна. • 2021 оны Хөдөө аж ахуйг дэмжих зээл: Зорилтын 500 тэрбум төгрөгөөс 494.3 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. • 2022 оны Хөдөө аж ахуйг дэмжих зээл: Зорилтын 380 тэрбум төгрөгөөс 222.3 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. • Том төслийн санхүүжилт: Зорилтын 2,000 тэрбум төгрөгөөс 66.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. **Монголын банкны холбоо** • ОУСК тай хамтарсан Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн (НСС) зах зээлийг хөгжүүлэх төслийг шат дараатай хэрэгжүүлэх ажлын явц

						сайн явж байна. 2020 оны 4-р улиралд энэ төслийг хамтран хэрэгжүүлэх санамж бичгийг ОУСК-тай байгуулж, банкны салбарт НСС-ийн практикийг цогцоор нэвтрүүлэх Банкны Ажлын хэсгийг ЗБДС-ийн төлөөллөөс оруулан нийт 15 гишүүнтэй байгуулав. Ажлын хэсгийн 4-дөх ээлжит уулзалтаар банкууд, мэдээллийн технологийн компаниудыг урин оролцуулж, НСС-д платформын технологи нэвтрүүлэх боломжийн талаар хэлэлцэв. • Банкны Ажлын хэсгийн уулзалт энэ онд цахимаар зохион байгуулагдаж, банкууд хоорондоо НСС-ийн бүтээгдэхүүн нэвтрүүлсэн, төсөл хэрэгжүүлсэн туршлагаасаа хуваалцаж энэ жил ажлын хэсгийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн тохиров. • ОУСК-ийн тусламжтай олон улсын тэргүүн туршлага практикийг агуулсан хоёр төрлийн гарын авлагыг монгол хэл дээр хэвлүүлэн гаргаж, банкны ажилчдад хоёр удаагийн вэбинар зохион байгуулж нийт 400 гаруй ажилчдыг хамруулж НСС, факторингийн үйл ажиллагааны талаар мэдлэг мэдээллийг өгч ажиллаа. • Цаашид энэ оны турш банкны ажлын хэсгийн төлөвлөгөөний хүрээнд олон төрлийн гарын авлага, судалгааны материалыг танилцуулах, банкны ажлын хэсгийн гишүүдийг илүү энэ чиглэлд мэдлэг олгох ажлууд хийгдэнэ • Өнгөрсөн онд банкны ажлын хэсэг, мэдээллийн технологийн компаниудтай хамтарсан уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, НСС-ийн чиглэлээр мэдээлэл технологийн шийдэл боловсруулах сонирхолтой компаниудын ерөнхий санал, нөхцөл байдлыг хэлэлцэв. энэ ажил 2022 онд илүү нарийн төлөвлөгөөтэй үргэлжлэхээр байна /50%/

						• ОУСК-тай хамтран Факторингийн үйлчилгээний гэрээг хэрхэн боловсруулах талаар болон Агуулахын санхүүжилтийг хөгжүүлэх чиглэлээр банкны ажилтнуудад сургалт зохион байгууллаа. • НСС-ын нэгдсэн платформ үүсгэх ажлыг ОУСК-ийн дэмжлэгтэй гүйцэтгэхээр төлөвлөж, технологийн хамтрагчийг сонгож гэрээлэх ажлыг эхлүүлээд байна. • ОУСК -аас боловсруулан гаргасан факторинг, НСС-ийн гарын авлага материал бэлэн болж холбогдох сургалт семинарыг зохион байгуулаад байна. • 2021 ондоо мөн цахим платформыг бий болгох ажлын эхлэлийг тавьж дотоодоо НСС-ийн чиглэлд систем хөгжүүлэн ажилладаг МТ-ийн компаниудтай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг хийсэн /40%/

			1.5.3.Банк, санхүүгийн салбарт хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулах, ач холбогдлыг сурталчлахад дэмжлэг үзүүлэх	**Монголын банкны холбоо** Гарын авлага материал бэлэн болоход үүн дээр суурилсан бодлого боловсруулагч, зохицуулагч байгууллагуудын холбогдох ажилтан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах, салбарын хэмжээнд НСС-ийн төрөлжилтийг зөв хэрэгжүүлэх зөвлөмж, заавар хамтран боловсруулах, НСС-ийн цахим платформыг бий болгох боломжийг банкны ажлын хэсгийн гишүүдтэй хамтран судалж, банкны салбарын дундын платформ бий болгоход шаардлагатай техникийн болон, санхүүгийн шаардлагыг тодорхойлох	2020-2024	**<u>Монголын банкны холбоо</u>** • ОУСК -аас боловсруулан гаргасан факторинг, НСС-ийн гарын авлага материал бэлэн болж холбогдох сургалт семинарыг зохион байгуулаад байна. • Энэ ондоо мөн цахим платформыг бий болгох ажлын эхлэлийг тавьж дотооддоо НСС-ийн чиглэлд систем хөгжүүлэн ажилладаг МТ-ийн компаниудтай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг хийсэн. /40%/
				Монголбанк ОУСК, Монголбанкны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх.		**<u>Монголбанк</u>** Монголбанк “Урт хугацаат своп хэлцлийн журам”- ын хүрээнд банк, Монгол Улсын Засгийн газар, олон улсын санхүүгийн байгууллагатай УХСХ байгуулах боломжтой байдаг. Монголбанк 2023 оноос 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл ОУСК-ийн банкуудад олгосон эх үүсвэрээр нийт 270 сая ам.долларын УХСХ байгуулсан байна.

			1.5.4.Жижиг, дунд аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, эрэлт, хэрэгцээнд тохирсон санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, хөдөө аж ахуйн салбарын өртгийн сүлжээнд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх	**Монголын банкны холбоо** Сонгосон 2-3 эдийн засгийн салбаруудад НС-ний зураглал гаргах үйл ажиллагааг хийж гүйцэтгэх, ЖДБ эрхлэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх, семинар, вебинарыг удаа дараа зохион байгуулж банкны НСС-ийн боломжийг илүү олон бизнес ААН-үүдэд таниулах ажлыг Монголбанк, ОУСК бусад талуудтай хамтран гүйцэтгэх.	2020-2024	**Монголын банкны холбоо** • Энэ ажлыг гүйцэтгэхээр банкны НСС-ийн ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгасан. • Эдийн засгийн салбаруудад НС-ний зураглал гаргах ажлыг ОУСК-аас эхлүүлсэн байгаа тул эхний драфт материалууд бэлэн болохоор банкны ажлын хэсэгт танилцуулж санал авах уулзалт хийгдэх байгаа • ЖДБ-ийн дунд банкны НСС-ийн бүтээгдэхүүний боломжийг таниулах хэлэлцүүлэг зохион байгуулахаар банкны ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгасан бөгөөд холбооноос МҮХАҮТ-тай холбогдож энэ ажлыг хэрэгжүүлнэ.
				Монголбанк Өртгийн сүлжээний санхүүжилтийг банк санхүүгийн байгууллагууд, ЖДҮ эрхлэгч нарт танилцуулах хурал, арга хэмжээг ОУСК-тай хамтран зохион байгуулах, оролцох.		**Монголбанк** Олон улсын байгууллагаас бага хүүтэй, урт хугацаат эх үүсвэр татахад шаардлагатай “Банк хоорондын валютын үүсмэл хэрэгслийн ерөнхий гэрээ” (ISDA)-г ОУ-ын байгууллага болох Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банк (EBRD)-тай 2021 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр байгуулсан бөгөөд 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 4.1 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийг байгуулаад байна. Тус эх үүсвэрээр EBRD нь өртөг багатай төгрөгийн санхүүжилтийг дотоодын ААН-үүдэд олгох юм. Түүнчлэн тус мастер гэрээг ОУСК-тай байгуулахаар санал солилцон ажиллаж байна.
				Засгийн газар		**Засгийн газар.** Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ажлын байрыг дэмжих зээл, репо санхүүжилтийн зээлийг олгож байна. Энэхүү

						хүрээнд 2024 оны III улирлын эцсийн байдлаар дараах гүйцэтгэлтэй байна. Үүнд: • Ажлын байрыг дэмжих зээл (ААН, иргэд): Зорилтын 2,000 тэрбум төгрөгөөс 1,952.6 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. • РЕПО санхүүжилтийн дүн: Зорилтот дүн болох 2,000 тэрбум төгрөгөөс 1,821.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. • Ипотекийн зээл: 2021 оноос 2024 оны 3 улирал хүртэлх хугацаанд нийт 3.8 их наяд төгрөгийн санхүүжилтийг 39.6 мянган өрхөд олгоод байна. • Хөдөө аж ахуйг дэмжих зээл: Зорилтын 500 тэрбум төгрөгөөс 453.4 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. • Том төслийн санхүүжилт: Зорилтын 2,000 тэрбум төгрөгөөс 66.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.
			1.5.5.Гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах санхүүгийн үүсмэл хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх	**Монголбанк** Гадаад валютын үүсмэл хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр судалж, үүсмэл хэлцлийн нөхцөл, холбогдох журамд шаардлагатай өөрчлөлтийг хийх. Олон улсын байгуулагуудтай үүсмэл хэрэгсэл байгуулж, өртөг багатай, төгрөгийн санхүүжилт олгох нөхцөлийг бүрдүүлнэ.	2020-2024	**<u>Монголбанк</u>** Гадаад болон дотоод зах зээлийн нөхцөл байдал, банкуудын гадаад эх үүсвэрийн өртөг зэргийг харгалзаж, 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгчийн А-162 дугаар тушаалаар “Урт хугацаат своп хэлцлийн журам”-ыг, 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгчийн А-304 дүгээр тушаалаар “Валютын своп, форвард хэлцлийн журам”-ыг тус тус шинэчлэн батлсан. Түүнчлэн, Монголбанкны Ерөнхийлөгчийн дараах тушаалуудаар УХСХ-ийн журам, хүүний нөхцөлд зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөлт оруулсан болно. • 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А-7 дугаар тушаал

						• 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А-164 дүгээр тушаал • 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн А-237 дүгээр тушаал • 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А-283 дугаар тушаал • 2023 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А-168 дугаар тушаал Мөн УХСХ-ийн журмын хүрээнд олон улсын санхүүгийн байгууллагууд Монголбанктай УХСХ байгуулах боломжтой.
				Санхүүгийн зохицуулах хороо Гадаад валютын үүсмэл хэрэгслийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр санал боловсруулах		**Санхүүгийн зохицуулах хороо** Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу "Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам"-ын төслийг боловсруулж, СЗХ-ны 2023.06.02-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор батлаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023.06.14-ны өдрийн 6251 дугаарт бүртгэгдсэн. Ингэснээр үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргах замаар санхүүгийн зах зээлд санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх суурь эрх зүйн орчин бүрдсэн.
			1.5.6.Банкны зээлийн бүтээгдэхүүнийг боловсронгуй болгож, иргэдийн шууд орлогоор барьцаалсан бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулах	**Монголбанк, МБХ** Иргэдийн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаа, хугацаа, орлогын түвшин зэрэг хүчин зүйлстэй нь уялдуулан		**Монголбанк** Монголбанкны зүгээс иргэдийн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны талаарх тайлан, тоон мэдээллийг банкуудаас сар бүр авч, иргэдийн хэрэглээний зээлийн дарамт, өр, орлогын харьцаа, хугацааны өөрчлөлтийг тогтмол хянан судлаж байна. Хэрэглээний зээлийн

				судлах, холбогдох эрсдэлийг харгалзан үзэж шаардлагатай тохиолдолд мөчлөг сөрсөн байдлаар бодлогын санал боловсруулж тухай бүр танилцуулах.		дундаж өр, орлогын харьцаа 2024 оны 8 дугаар сарын байдлаар 48.5 хувь байна. Түүнчлэн, арилжааны банкуудын хэрэглээний зээлийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх "Өр, орлогын харьцаа тооцох аргачлал"-ыг шинэчлэн боловсруулж, Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 3 дугаар улирлын ээлжит хурлаар баталлаа. Мөн автомашины зээлийн өсөлтийг сааруулж, автомашины импортыг бууруулах, цаашлаад энэ төрлийн бүтээгдэхүүний валютын ханш, төлбөрийн тэнцэлд учруулах дарамтыг нэмэгдүүлэхгүй байх зорилгоор суудлын автомашины зээлд Зээл-Үнэлгээний харьцаа (ЗҮХ) тогтоох бодлогын санал боловсруулж Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 1 дүгээр улирлын ээлжит хурлаар хэлэлцүүлсэн. Түүнчлэн, автомашины зээлд зээл, үнэлгээний харьцаа (ЗҮХ) тогтоох саналыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А-1/91 албан тоот бичгээр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн гишүүдэд ажлын журмаар танилцуулж, холбогдох саналуудыг авсан. Санхүүгийн зохицуулах хорооноос "Банкны болон банкны бус санхүүгийн салбараас олгох автомашины зээлд зээл-үнэлгээний харьцаа (ЗҮХ)-г нэвтрүүлж, мөрдүүлэхтэй холбоотойгоор нэгдсэн судалгааг хамтран хийж, зах зээл тус бүрээр нарийвчлан гаргасан дүгнэлтэд үндэслэн шийдвэрлэх" саналыг ирүүлсэн бол Сангийн яам болон ХДК-аас уг асуудалд тусгайлан өгөх саналгүй болохоо мэдэгдсэн. Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 4 дүгээр улирлын ээлжит хурлаар хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны болон хугацааны хязгаарлалтыг чангатгах санал боловсруулж хэлэлцүүлэв. Мөнгөний бодлогын хороо тус асуудлыг банк болон банкны бус салбарт харилцан уялдаатайгаар авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн тул Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл

						(СТБЗ)-ийн хурлаар холбогдох асуудлыг хэлэлцүүлсний дараа МБХ-ны хурлаар дахин хэлэлцэхээр тогтсон. Улмаар уг асуудлыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А-1/91 албан тоот бичгээр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн гишүүдэд ажлын журмаар танилцуулж, холбогдох саналуудыг авсан. Сангийн Яам болон Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс банкны салбарт хэрэгжүүлж буй хэрэглээний зээлийн хязгаарлалтын арга хэмжээг банкны бус салбарт давхар мөрдүүлэх нь зохицуулалттай хуулийн этгээдээс хэрэглээний зээл авах иргэдийн боломжийг хязгаарлах, улмаар өндөр хүүтэй бусад эх үүсвэрийг хайхад хүргэх, мөн бүртгэлгүй санхүүгийн үйлчилгээ, далд эдийн засгийн цар хүрээг тэлэх, хэрэглэгчдийн хүүгийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэл үүсэж болзошгүй тул тус зохицуулалтыг ББСБ-ын салбарт хэрэгжүүлэхэд тохиромжгүй гэсэн саналыг ирүүлсэн. Түүнчлэн, тэтгэвэр барьцаалсан зээлийн хувьд зээлдэгчид тэтгэврийн орлогын дийлэнхийг барьцаалан урт хугацаатай зээл авч байгаа нь зээлдэгчид наад захын амьжиргааны зардлаа хангаж чадахгүйд хүрэх, өрийн дарамтад орох эрсдэл нэмэгдсэн тул тэтгэврийн зээл олголтод хязгаарлалт тавих шаардлага үүсэв. Иймд тэтгэврийн зээл олголтыг зохистой түвшинд хязгаарлах санал боловсруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн дугаар А-1/1311 тоот албан бичгээр хүргүүлээд байна. Сүүлийн 2 жил орчмын хугацаанд нэрлэсэн цалин, тэтгэврийн орлогын өсөлтийг дагаад банкны салбараас олгох иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт эрчимжихийн зэрэгцээ банк болон ББСБ-аас давхар зээлтэй иргэдийн тоо нэмэгдэж, санхүүгийн салбарт нийтлэг хамаарал (common exposure)-аас үүдэлтэй эрсдэл бодитоор тулгарч байна. Иймд Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 2

220

						дугаар улирлын ээлжит хуралдаанаар банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөл өөрчилсөн хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцаа (ӨОХ)-ны дээд хязгаарыг 55 хувь болгон бууруулах шийдвэрийг гаргаад байна. Нөгөөтэйгүүр, санхүүгийн зах зээлийн хүртээмж, санхүүгийн бүтээгдэхүүний хөгжлийг дэмжих зорилгоор бага дүнтэй кредит картын зээлд болон тодорхой нөхцөлүүдийг хангасан дээд боловсролын сургалтын төлбөрийн зээлд ӨОХ-ны болон хугацааны хязгаарлалтыг мөрдүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн.
		1.6.Санхүүгийн салбарт дотоод эх үүсвэр гадаад валютаар бүрдэж байгааг бууруулах	1.6.1.Санхүүгийн салбарт дотоод эх үүсвэрийн хуримтлал гадаад валютаар бүрдэж байгааг бууруулах чиглэлд макро зохистой бодлогын шинэ хэрэгслийг нэвтрүүлэх	**Монголбанк** Дотоод эх үүсвэрийн долларжилтыг бууруулах чиглэлд бодлогын арга хэрэгслүүдийг судалж, шаардлага үүссэн үед бодлогын санал боловсруулж танилцуулах.	2020-2024	**<u>Засгийн газар, Монголбанк</u>** Дотоод эх үүсвэрийн долларжилтыг тогтмол хянаж байна. Иргэд, аж ахуйн нэгжийн харилцах хадгаламжийн долларжилт өсөх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 34.4 хувьд хүрлээ. Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 4 дүгээр улирлын хурлаар банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор Банкууд дахь гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тооцох заавал байлгах нөөцийн хувийг 3 нэгж хувиар нэмэгдүүлж 18 хувьд хүргэх шийдвэр гаргаж байсан. Харин Монголбанкны МБХ 2024 оны 7-р сарын ээлжит хурлаар олон улсад эрсдэлгүй хүүгийн түвшин өндөр хэвээр хадгалагдаж, гадаад валютын ЗБН-ийн шаардлага өндөр байсан нь банкуудын эх үүсвэрийн зардлыг өсгөж байгаатай холбогдуулан банкуудын гадаад валютын ЗБН-ийн 3 нэгж хувиар бууруулж, 15 хувьд хүргэх шийдвэрийг гаргасан. Түүнчлэн Монголбанкны МБХ 2024 оны 9-р сарын ээлжит хурлаар Банкны салбарын зээлийн өсөлт эрчимжиж, хэрэглээний импортыг урамшуулах, дотоод эрэлтийг өдөөх, цаашлаад санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх зорилгоор төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээг 2 нэгж хувиар нэмэгдүүлэн 10

						хувьд хүргэхээр шийдвэрлээд байна. Эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай хуулийн төсөлд долларжилтыг бууруулах зорилго бүхий зохицуулалтын саналыг Засгийн газарт хүргүүлэв. **<u>Хадгаламжийн даатгалын корпораци</u>** Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн Гадаад валютын хадгаламжийн хураамж тооцохгүй байх зохицуулалтыг түр журам гарган хэрэгжүүлж байна. Энэхүү түр зохицуулалт нь хууль хэрэгжүүлэх хугацаанд бүрэн хэрэгжлээ.
			1.6.2.Гадаад валютын хадгаламжийн хүүгийн орлогод ногдуулах татварын хэмжээг нэмэгдүүлэх	**Татварын ерөнхий газар** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудын холбогдох заалтуудад гадаад валютын хадгаламжийн хүүгийн орлогод ногдуулах татварын хэмжээг нэмэгдүүлэх нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг, ажлын хэсгийн шийдвэр, Монгол банкны мэдээлэлд хийсэн тооцоо судалгаанд үндэслэн боловсруулах ажлын хэсэгт ажиллах;	2020-2024	**<u>Татварын ерөнхий газар</u>** Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, хөрөнгийн зах зээлийн эргэлтийг дэмжих, 2023 оноос эхлүүлсэн татварын бодлогыг өргөжүүлэх зорилгоор дараах татварын бодлогын арга хэмжээ нь 2024 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн. Үүнд: 1. Хөрөнгийн зах зээлийн эргэлтийг дэмжих, бүртгэлийг сайжруулах, хөрөнгө оруулалтын татварын орчныг тодорхой болгох зорилгоор үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалсан хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдуулах орлогын албан татварыг 2027 он хүртэл 90 хувь, 2029 он хүртэл 50 хувиар үе шаттай хөнгөлж байна; 2. Монголын үнэт цаасны зах зээлээс худалдан авсан үнэт цаасаа борлуулахад дотоодын хөрөнгө оруулагч анх худалдаж авсан дүн болон шимтгэлийн зардлаа хасаж, ашгаас татвараа тооцдог бол гадаадын хөрөнгө оруулагч мөн хувьцаа, бусад үнэт цаас борлуулахад гадаад,

						дотоодын хөрөнгө оруулагч ижил нөхцөлөөр холбогдох зардлыг хасаж тооцох боломжийг нээсэн; 3. Хөрөнгө оруулагчдын татварын харилцааг хялбаршуулж, тайлан гаргах үүргээс чөлөөлж, хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламж болон кастодианы үйл ажиллагаа эрхэлдэг этгээд нэгдсэн журмаар суутган тооцож, төсөвт төлөх зэрэг болно.
			1.6.3.Банкны гадаад зах зээлээс татсан гадаад валютын эх үүсвэрийг үндэсний мөнгөн тэмдэгтэд хөрвүүлж, бага хүүтэй зээл олгох боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, уламжлах	**Монголбанк** Санхүүгийн үүсмэл хэрэгсэлтэй холбогдсон эрх зүйн орчинг бий болгох талаар холбогдох судалгаа хийж санал боловсруулах.	2020-2024	**<u>Монголбанк</u>** 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгчийн А-162 дугаар тушаалаар "Урт хугацаат своп хэлцэл"-ийн журмыг шинэчлэн батлаж, хүүний нөхцөлд өөрчлөлт оруулсан. Түүнчлэн, гадаад, дотоод зах зээлийн нөхцөл байдал, банкуудын гадаад эх үүсвэрийн өртөг зэргийг харгалзаж, 2023 он хүртэл нийт 5 удаа журамд холбогдох өөрчлөлт оруулж, хүүний нөхцлийг өөрчилснөөр банкны гадаад зах зээлээс татсан валютын эх үүсвэрийг төгрөгт хөрвүүлэн бага хүүтэй зээл олгох боломжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ долларжилт, түүнтэй холбогдох эрсдлийг бууруулан ажилласан. Мөн 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгчийн А-304 дүгээр тушаалаар "Валютын своп, форвард хэлцлийн журам"-ийг шинэчлэн баталсан. Энэ нь арилжааны банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-137 дугаар тушаалаар Санхүүгийн үүсмэл хэрэгслийг зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулах. хэрэгцээ шаардлагыг тандан судлах, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын

						хэсгээс хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу тандан судалгааг гүйцэтгэж холбогдох хуулийн төслийн саналыг боловсруулаад байна.
			1.6.4.Гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй байх болон иргэн, хуулийн этгээд хоорондын гүйлгээ, төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх талаар Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	**Монголбанк, Засгийн газар** Пассивын долларжилтыг бууруулах үүднээс гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй байх, зохицуулалтыг бий болгох зорилгоор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, хууль санаачлагчид уламжлан хамтран ажиллах;		**<u>Монголбанк, Засгийн газар</u>** Засгийн газраас санаачилсан Эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай хуулийн төсөлд долларжилтыг бууруулах зорилгын хүрээнд Монголбанк, ХДК-аас авч хэрэгжүүлэх арга хэмжээнд холбогдох саналыг хүргүүлж ажилласан. Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Улсын Их хурлын чуулганы хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэх чиг үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны Ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Монголбанкны дэд ажлын хэсэг хуулийн төслийн саналын томъёолол, холбогдох судалгаа, тайлбар, танилцуулга бэлтгэн ЭЗБХ-ны Ажлын хэсэгт хүргүүлэн ажилласан.
				Хадгаламжийн даатгалын корпораци		**<u>Хадгаламжийн даатгалын корпораци</u>** Гадаад валютын хадгаламжийг албан журмын даатгалд хамруулахгүй байх ажлын хүрээнд Гадаад валютад нөхөн төлбөр олгохгүй байх түр журам хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор Гадаад валютын харилцах, хадгаламжид хураамж тооцохгүй байх зохицуулалтын хүрээнд түр журам гарган хэрэгжүүлж байна. Энэхүү түр зохицуулалт нь Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн

						засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүчинтэй хугацаанд бүрэн хэрэгжлээ.
			1.6.5.Төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжийн гадаад валютын орлогыг 30 хоногийн дотор Монгол Улсад оруулах, гадаад валютаар гарах зардлаас давсан орлогыг төгрөгт хөрвүүлэх зохицуулалт бий болгох	**Засгийн газар**	2020-2021	**Засгийн газар** Төлбөрийн тэнцэл 2022 оны жилийн эцсийн байдлаар 1 тэрбум ам.долларын алдагдалтай гарч, гадаад валютын албан нөөц 3,399.6 сая ам.долларт хүрсэн. Уг нөөц нь валютын төлбөртэй барааны импортын нийт 4.7 сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагуудаас нийт 1,267.9 тэрбум төгрөг буюу 417.8 сая ам.долларын урт хугацаат, хөнгөлөлттэй төслийн зээл, 299.5 тэрбум төгрөг буюу 95.7 орчим сая ам.долларын гадаад тусламж, АХБ-аас 100 сая ам.долларын хөтөлбөрийн зээлийг авч ашигласан нь валютын нөөцийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөөг үзүүлсэн. Засгийн газраас 2022 оны 10 дугаар сард "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 362 дугаар тогтоол гаргаж хэрэгжүүлсэн нь гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэхэд нөлөөлж улмаар "Эрдэнэс Тавантолгой" ТӨХК, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ТӨҮГ, "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ууд болон "Оюу толгой" ХХК нийт 1.1 тэрбум гаруй ам.доллар улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Тухайлбал, "Эрдэнэс Тавантолгой" ТӨХК дээрх тогтоол батлагдсанаас хойш 12 сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд 588.5 сая орчим ам.долларын үнийн дүн бүхий 6.6 сая тонн нүүрс борлуулжээ. Мөн 2022 онд арилжааны банкууд гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас хэд хэдэн урт хугацаат санхүүжилтийг татсан нь валютын нөөц нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

						Мөн Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкнаас "Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд 100.0 сая ам.долларын санхүүжилтийг Төрийн сангийн дансанд 2023 оны 4 дүгээр сард хүлээн авсан. **Монголбанк** ЗГХЭГ-ын дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 3/3/А-5 дугаар хамтарсан тушаалын хүрээнд Монголбанк төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан ААНБ-уудаас гадаад валют худалдан авч байгаа билээ. Тус хамтарсан тушаалын хүрээнд 2019 онд 2,214.7 сая, 2020 он 1,776.5 сая, 2021 онд 2414.5 сая, 2022 онд 3518.6 сая, 2023 онд 4929.7 сая, 2024 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 4336.6 ам.доллар тус тус худалдан авчээ. Уг хамтарсан тушаалын хэрэгжилт, үйл ажиллагааг өргөтгөх чиглэлээр хамтран ажиллах албан хүсэлтийг ЗГХЭГ-т 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А-1/1240 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төрийн болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс Монголбанк валют худалдан авч буй арилжааны давтамж нь 2023 онд 2019 онтой харьцуулбал 3.3 дахин нэмэгдсэн байна. Харин 2024 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад арилжааны давтамж 1.1 дахин нэмэгджээ.
		1.7.Харилцах данс, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй, хүү, түүнтэй төстэй бусад төлбөр төлөхгүй байх агуулгаар холбогдох	1.7.1.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	**Монголбанк,** Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаж	2020-2021	**Хууль, зүй дотоод хэргийн яам** Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн А-411 дүгээр тушаалаар байгуулагдсан Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүнээр

		хууль тогтоомжид өөрчлөлт оруулах		хууль тогтоогчтой хамтран ажиллах. **Санхүүгийн зохицуулах хороо** Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллах, санал хүргүүлэн, хамтран ажиллах **Засгийн газар**		ажиллаж байгаа бөгөөд хуулийн төсөлд санал өгч хамтран ажиллаж байна. **<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** УИХ-д 2020.8.20-ны өдөр өргөн мэдүүлсэн Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Их Хурлын 2020.8.28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор УИХ-ын 2020 оны намрын чуулганы хэлэлцэх асуултын жагсаалтад багтсан. Иймд хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн ба ажлын хэсгийн бүрэлдэхүүнд СЗХ-ны төлөөлөл оролцож, холбогдох саналыг Монголбанканд хүргүүлсэн. "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай" хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2021.5.21-ний өдөр хэлэлцэн баталсан. **<u>Монголбанк</u>** Зээлийн эх үүсвэр болон үйл ажиллагааны зардлыг бууруулах, харилцагч, хадгаламж эзэмшигчийн хууль ёсны эрхийг хамгаалах зорилгоор банк, эрх бүхий этгээдээс иргэд, хуулийн этгээдэд санал болгож байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, зээл олгоход баримтлах суурь зарчим, бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг үндэслэлтэй тогтоохтой холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг УИХ-ын 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар баталж, 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна. Хууль батлагдсантай холбоотойгоор банкны зээл олгох үйл ажиллагааны журмыг Монголбанкны

						Ерөнхийлөгчийн 2022 оны А-311 дүгээр тушаалаар банкны зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээний журмыг Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан 2024 оны А/61,А/65 дугаар тушаалаар тус тус баталж, банкуудад мөрдүүлэн ажиллаж байна.
		1.8.Банкны салбарт өрсөлдөөнийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх	1.8.1.Монгол Улсад гадаадын банк үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	**Засгийн газар**	2020-2024	**<u>Монголбанк</u>** Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах үүрэг бүхий Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийг 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан бөгөөд 2021.10.12-ны өдрийн хуралдаанаар Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийг хөрөнгө оруулалтын банкийг үүсгэн байгуулагчийн харьяаллаар (гадаад, дотоод) ялгахгүйгээр арилжааны болон хөрөнгийн зах зээлд оролцох боломжтой, банкны салбарын дундаж

				Монголбанк Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөлд санал өгч хууль тогтоогчтой хамтран ажиллах.		хэмжээнээс дээш дүнтэй төсөл хөтөлбөр санхүүжүүлэх төрөлжсөн банк болгож өөрчлөхөөр шийдвэрлэсэн. Тус ажлын хүрээнд Монголбанк нь хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэгт орж ажиллан, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөлтэй хамтран хуулийн төсөлд банкны эрх зүйн байдал, үйл ажиллагааны төрөл, үүсгэн байгуулах шаардлага, хяналт шалгалт гэсэн чиглэлээр өөрчлөлтийг оруулан ажиллаж байна. Эцэслэн боловсруулсан хуулийн төслийг УИХ 2023 оны 1 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд хэлэлцэж Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийг баталсан. Хууль батлагдсантай холбоотой шаардлагатай холбогдох журмын төслүүдийг боловсруулж, батлан, хууль хэрэгжиж эхлэх хугацаа буюу 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдөрт багтаан Захиргааны ерөнхий хуулийн дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. Энэ хүрээнд гадаадын банк Монгол Улсад байгуулагдах, банкны үйл ажиллагаа явуулах талаарх харилцааг Банкны тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай, Компанийн тухай хууль болон Монголбанкны Банкны зөвшөөрлийн журам, Банкны нэгжийн журмаар зохицуулж байна. Холбогдох журмын зохицуулалтыг 2023 оны 1 дүгээр сараас хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх, Базелийн хорооны олон улсын зарчмын зохицуулаттай уялдуулах байдлаар гадаадын болон дотоодын банкны салбар байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох эрх зүйн үндсийг боловсронгуй болгох зорилгоор Гадаадын банкны нэгжийн журам болон Дотоодын банкны нэгжийн журмын төслийг боловсруулаа.

	Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах	2.1.Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг, маргааныг зардал багатай шийдвэрлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2.1.1.Зээл төлөх хөшүүргийг ашиглаж, чанаргүй зээлийг төлүүлэх, барьцаа хөрөнгөөр зээлийн төлбөрийн үүргийг хангуулах ажиллагааг эрчимжүүлэх, шүүхийн бус журмаар шийдвэрлэх агуулгаар Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай, Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	**Засгийн газар** **Монголбанк** Хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Санхүүгийн түрээсийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Татварын багц хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хөдлөх хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж хууль санаачлагчид уламжилж хамтран ажиллах.	2020-2021	**Хууль, зүй дотоод хэргийн яам** Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн А-411 дүгээр тушаалаар байгуулагдсан Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд хуулийн төсөлд санал өгч хамтран ажиллаж байна. **Монголбанк** Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Монголбанк, ХЗДХЯ, Сангийн яам, Монголын Банкны Холбооны төлөөллийг оролцуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгээс Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж ХЗДХЯ-д хүргүүлээд байна. 2021 оны 12 дугаар сард УИХ-ын тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын 5 дугаар хавсралтад заасан Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Төлбөрийн чадваргүйдлийн тухай, Шүүхийн бус журмаар өр барагдуулах тухай анхдагч хуулийн төсөл, Иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай анхдагч хуулийн төсөл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023

						онд үе шаттайгаар эцэслэн боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж хэлэлцүүлэх ажилд төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдан шуурхай, үр нөлөөтэй хэрэгжүүлдэг байх, шүүх болон бусад оролцогчдод учирдаг хүндрэлийг арилгах зорилгоор шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг бий болгох, маргаан бүгатай, бага үнийн дүнтэй болон банк, эрх бүхий этгээдийн олгосон зээл, түүний үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбоотой хэргийг бусад иргэний хэргээс ялгамжтай авч үзэн, уг төрлийн онцлогт нийцсэн хялбаршуулсан журмыг бий болгох, , шүүгч нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулах ажиллагааны хүрээнд хариуцагчийн тогтоох, эрэн сурвалжлах үйл ажиллагааг цагдаагийн байгууллагаар байгууллагаас ангид байдлаар мэргэжлийн албаар гүйцэтгүүлдэг байх, хэргийн онцлогтой холбоотойгоор өмгөөлөгчгүй орох боломжтой хэргийг тодорхойлох, гадаад улсаас нотлох баримт бүрдүүлэх үйл ажиллагааг тусгах, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах асуудлыг нарийвчлан зохицуулах, тухайлбал үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотойгоор төлбөр гаргуулах эд хөрөнгийг нарийвчлан заах, үнэлгээг тогтоох процессыг ИХШХШТХ-д тусгах саналыг Ажлын хэсэгт дэвшүүлсэн. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар олон улсын сайн туршлага, шийдлийг судлаж Монгол Улсын хууль тогтоомжид тусгах санал боловсруулах ажлыг хөндлөнгийн мэргэжлийн судалгааны багаар гүйцэтгүүлж тайланг ХЗДХЯ-д хүргүүллээ. Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор Банкны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай

			2.1.2.Үүргийн гүйцэтгэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хангуулах явцад санхүүгийн хөрөнгийн үнэлгээ, эх үүсвэрийн өртгийг хадгалах, хамгаалах агуулгаар Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	**Засгийн газар** **Монголбанк** Хуулийн төслийг боловсруулж хууль санаачлагчид уламжилж хамтран ажиллах.	2020-2021	хууль зэрэг хууль болон Монголбанкны холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, төслийг боловсруулсан. **<u>Засгийн газар</u>** Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд хуулийн төсөлд санал өгч хамтран ажиллаж байна. **<u>Монголбанк</u>** Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Монголбанк, ХЗДХЯ, Сангийн яам, Монголын Банкны Холбооны төлөөллийг оролцуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгээс Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж ХЗДХЯ-д хүргүүлсэн. 2021 оны 12 дугаар сард УИХ-ын тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын 5 дугаар хавсралтад заасан Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Төлбөрийн чадваргүйдлийн тухай, Шүүхийн бус журмаар өр барагдуулах тухай анхдагч хуулийн төсөл, Иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай анхдагч хуулийн төсөл, Иргэний хэрэг шүүхэд хянан

						шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 онд үе шаттайгаар эцэслэн боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж хэлэлцүүлэх ажилд төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна. Зээлийн эх үүсвэр болон үйл ажиллагааны зардлыг бууруулах, харилцагч, хадгаламж эзэмшигчийн хууль ёсны эрхийг хамгаалах зорилгоор банк, эрх бүхий этгээдээс иргэд, хуулийн этгээдэд санал болгож байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоох, зээл олгоход баримтлах суурь зарчим, бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг үндэслэлтэй тогтоохтой холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг УИХ-ын 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар баталж, мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна. Хууль батлагдсантай холбоотойгоор зээл олголтын журам, барьцаа хөрөнгийн үнэлгээний журмын төслийг тус тус боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу баталж мөрдүүлэхээр ажиллаж байна.

			2.1.3.Санхүүгийн хэрэгслийг ангилах, хэмжих, түүний үнэ цэний бууралтыг тооцох тухай Санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандартыг банкуудад мөрдүүлэх	**Засгийн газар, Монголбанк** Санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандартыг нэвтрүүлэх зорилгын хүрээнд банкны хяналт шалгалтын чадавхийг бэхжүүлэх.	2020-2024	**Монголбанк** Монголбанк Азийн Хөгжлийн Банк (АХБ)-тай "Банкны салбарын тогтвортой байдлыг хангах, үр ашгийг сайжруулах" техник туслалцааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд банкны нягтлан бодох бүртгэлд СТОУС 9-г нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Монголбанкны хянан шалгагч нарыг чадавхжуулахаар СТОУС 9 сэдвээр сургалтуудыг зохион байгуулсан бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам" болон нягтлан бодох бүртгэлийн багц материалыг СТОУС 9-т нийцүүлэн шинэчилж байна.
			2.1.4.Банкны тогтворжуулалтын сангийн бүрдүүлэлт, түүний зарцуулалт, хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулах журам, банкнаас банкийг тогтворжуулах болон Монголбанкнаас банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх журмыг олон улсын сайн туршлагад үндэслэн боловсруулж, банкны өр барагдуулах тогтолцоог боловсронгуй болгох	**Монголбанк Засгийн газар,** Банкны тогтворжуулалтын сангийн бүрдүүлэлт, түүний зарцуулалт, хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулах журмыг боловсруулж, батлуулах. Банкийг тогтворжуулах болон Монголбанкнаас банкны бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх журмыг боловсруулж, батлуулах.	2020-2024	**Монголбанк** Системийн нөлөө бүхий банканд үүсэх системийн болон тухайн банкны хэмжээний хүндрэлийн үед эдийн засагт бодит сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлж, банкны системээс бүрдүүлсэн дундын буюу тогтворжуулалтын сангаас богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор "Банкны тогтворжуулалтын сангийн журам"-ын төслийг боловсруулж Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн А-155 дугаар тушаалаар батлаж, ХЗДХЯ-д Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн бөгөөд журмын дагуу жилийн хураамжийг тогтоон 2022 оноос авч эхэлсэн. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А-184 дугаар тушаалаар "Банкны тогтворжуулалтын сангийн жилийн хураамжийг тооцох аргачлал"-ыг батлаж 2024 оны хураамжаас эхлэн батлагдсан аргачлалтын дагуу үндсэн болон банкны

						эрсдэлийн түвшингээс хамаарсан нэмэлт хувь хэмжээ гэсэн 2 хэсгээс бүрдсэн хураамжийг банкны тогтворжуулалтын санд төвлөрүүлэн ажиллаж байна
				Санхүүгийн зохицуулах хороо Төрийн байгууллагуудтай хамтран ажиллах		**<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** Ажлын хэсэг байгуулагдсан тохиолдолд хамтран ажиллах боломжтой байна.
		2.2.Банкны засаглал, хяналтыг сайжруулах	2.2.1.Банкны зохистой засаглалын журмыг олон улсын жишигт нийцүүлж өөрчлөх	**Монголбанк** "Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам"-д олон улсын жишигт нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах.	2020-2021	**<u>Монголбанк</u>** Банкны засаглалыг сайжруулах ажлын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А-143 дугаар тушаалаар " Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам"-ыг нэмэлт өөрчлөлт оруулан батлсан. Харин журмыг олон улсын жишигт нийцүүлэн, сайжруулах үүднээс журмын шинэчилсэн найруулгын төслийг олон улсын сайн туршлагыг үндэслэн боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.
			2.2.2.Банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, банк хувьцаат компанийн хэлбэртэй байх агуулгаар Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, уламжлах	**Монголбанк** УИХ-ын гишүүн Б.Баттөмөрийн УИХ-д өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгч хууль тогтоогчтой хамтран ажиллах.	2020-2024	**<u>Монголбанк</u>** Банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, зохистой засаглалын зарчим, олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох, банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, банкуудыг хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулах чиглэлийн хүрээнд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар батлсан. Дээрх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах журмуудыг боловсруулж, батлсан. Үүнд:

						• Банкийг хувьцаат компанийн хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих түр журмыг боловсруулж батлагдсан; • Банкны системд нөлөө бүхий банкийг тогтоох аргачлалыг боловсруулж батлагдсан; • Хувьцаат компанийн хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журмыг боловсруулж батлагдсан; • Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан; • Банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, хэрэгжүүлэх журмыг шинэчлэн батлагдсан; • Банкийг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн батлагдсан; • Банкны нөхцөлт удирдлагын арга хэмжээ, бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-366 дугаар тушаалаар “Эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийг батлагдсан. Шинэтгэлийн хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар банкны системд нөлөө бүхий 5 банкнаас хувьцаагаа анхдагч зах зээлд, олон нийтэд санал болгон, гаргах замаар нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр, бусад 6 банкны 3 нь хаалттай хувьцаат компанийн хэлбэртэйгээр тус тус өөрчлөн байгуулагдаад байна.

						Энэ хүрээнд Монголбанк нь банкны системд нөлөө бүхий банкнуудыг олон нийтэд хувьцаагаа гарган компанийн хэлбэрээ өөрчлөхөөс урьдаж хараат бус "Активын чанарын үнэлгээ"-г олон улсын хөндлөнгийн аудитын компаниар үнэлүүлэх ажлыг зохион байгуулж, банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээг тодорхойлж, үнэлгээний үр дүнг боломжит хөрөнгө оруулагчид болон олон нийтэд танилцуулсан нь банкны системийн мэдээллийн ил тод байдлыг хангаж, улмаар банкууд хувьцаагаа анхдагч зах зээлд амжилттай арилжаалах урьдач нөхцөлийг бүрдүүлсэн. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу арилжааны банкууд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор холбогдох хуулийн дагуу компанийн хэлбэрээ өөрчилсөн байх, 2023 оны 12 дугаар сард багтаан компанийн хувь эзэмшилд тавигдах шаардлагыг биелүүлсэн байх шаардлагатай байсныг 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн Улсын их хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэн, 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан.
			2.2.3.Банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, ашигт ажиллагааны зорилт, гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллыг тухайн санхүүгийн жил, үйл ажиллагаа, ашигт ажиллагаагаар бус урт хугацааны үзүүлэлт, үр дүнгээр тогтоодог байх агуулгаар холбогдох журам гаргаж, хэрэгжүүлэх	**Монголбанк** Банк салбарын эрүүл, тогтвортой үйл ажиллагааг төлөвшүүлэх зорилгоор олон улсын сайн туршлагыг судлан холбогдох эрх зүйн баримт бичгийг боловсруулан батлуулах.	2020-2024	**<u>Монголбанк</u>** Банкны тухай хуулийн банканд Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт "Банк нь Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкнаас тогтоосон дүрэм, журам, шийдвэрийг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүссэн, банкны тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй, эсхүл найдваргүй, хэвийн бус үйл ажиллагаа явуулсан бол Монголбанкнаас дараахь арга хэмжээг авна." гэж заасан бөгөөд авах арга хэмжээний заалтад банкны удирдах албан тушаалтанд хариуцлага тооцох: 1. 48.1.6. банкны удирдах албан тушаалтны урамшууллын тогтолцоо нь банкны өөрийн хөрөнгийн

						хангалттай байх түвшинд сөргөөр нөлөөлнө гэж Монголбанк дүгнэсэн бол цалин, урамшууллыг хязгаарлах; 2. 48.1.12.банкны гүйцэтгэх удирдлагыг албан тушаалаас түдгэлзүүлэх, чөлөөлөх зэрэг заалтууд байдаг. Мөн 2024 оны Улсын их хурлын намрын чуулганаар хэлэлцүүлэх Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд 48.1.12 дахь заалтын "удирдлагыг" гэснийг "захирлыг" гэж өөрчлөн банкны тогтвортой үйл ажиллагааг алдагдуулсан болон алдагдуулж болзошгүй үйл ажиллагаа явуулсан гүйцэтгэх захиралд хариуцлага тооцох өөрчлөлтийг оруулахаар боловсруулсан. Мөн банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх хүрээнд Базел стандартын Бүлэг 2-ын өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP, ILAAP), хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ыг сүүлийн 2 жилийн турш туршилтын байдлаар хэрэгжүүлж, холбогдох журмын төслүүдийг боловсруулаад байна. Тухайлбал, банкнууд ICAAP, ILAAP-н туршилтын тайланг боловсруулж, бэлтгэсэн тайланг Монголбанкнаас хяналт шалгалтын үнэлгээний аргачлалаар үнэлэх ажлыг гүйцэтгэсэн бөгөөд өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлалын журмын төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Уг журмын хүрээнд банкыг үнэлж, гарсан үр дүнд үндэслэн банканд тохирох арга хэмжээг Монголбанкнаас авч хэрэгжүүлэх боломжтой болно.
				Санхүүгийн зохицуулах хороо ББСБ-уудын засаглалыг сайжруулах, үүргийг нэмэгдүүлэх		**<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** СЗХ-ны 2022 оны 145 дугаар тогтоолоор "Компанийн засаглалын кодекс"-ыг шинэчлэн баталж эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байх,

				зохицуулалтыг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусган эрх зүйн орчинг бүрдүүлэх.		компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгахаар заасан. Мөн кодексийн хавсралтаар залгамж халааны бодлогын, цалин, урамшууллын бодлогын бичиг баримтын загварыг оруулсан. ББСБ-уудын зээлийн бүтээгдэхүүн, хугацаа, хүү, шимтгэл, хураамжийн талаарх мэдээллийн загвар маягтыг боловсруулж, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоонд 2021.03.25-ны өдрийн 7/1115 тоот албан бичгийг хүргүүлсэн. Үүний дагуу СЗХ-ноос Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны цахим сайтад байршуулах ажлыг мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулж, www.bbsb.mn сайтад зээлийн бүтээгдэхүүн, хүү, шимтгэл хураамжийн мэдээллийг тавьж олон нийтэд мэдээлж байна. Салбарын нөлөө бүхий олон үйлчлүүлэгчтэй финтек үйлчилгээ үзүүлж буй нэр бүхий 37 ББСБ-уудын хувьд өөрийн цахим сайт, аппликейшнээр дамжуулан бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг үйлчлүүлэгчдэд хүргэж байна.
		2.3.Банкны эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх	2.3.1.Зээлийн нийлүүлэлтийн тасалдлаас сэргийлж банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах зорилгоор банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх	**Монголбанк, Засгийн газар** Эрсдэл хамгаалах нөөц, хөшүүргийн харьцаа болон төвлөрлийн эрсдэлийг бууруулах зохистой харьцаа зэрэг банкны үйл ажиллагаанд шинэчлэн тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг банкуудад нэвтрүүлэх	2020-2021	**<u>Монголбанк</u>** Монголбанкны Ерөнхийлөгч (МБЕ)-ийн 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А-139 тоот тушаалаар “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор эрсдэл хамгаалах нөөц, хөшүүргийн харьцаанд зарим зохицуулалтыг оруулж батална. Ковид-19 цар тахлын нөлөө банкны салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхөөр байгаа харгалзан дээрх тушаалаар тогтоосон шалгуур үзүүлэлтийг шат дараатайгаар банкуудад нэвтрүүлэхээр МБЕ-ийн 2020 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн А-314 тоот тушаалаар батална бөгөөд 2022 оны 07 дугаар сарын

						01-ний өдрөөс тус үзүүлэлтийг банкуудад бүрэн нэвтрүүлсэн. Банкны системд нөлөө бүхий банкуудад Активын чанарын үнэлгээг хийж, банкуудын өөрийн хөрөнгө, эрсдэлийн сангийн хүрэлцээг тодорхойлсон. Активын чанарын үнэлгээний үр дүнгээр банкны системийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх, улмаар банкны тогтолцооны тогвортой байдлыг хангах хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажилласан.
		2.4.Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх	2.4.1.Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох	**Монголбанк** Хуулийн төслийг сайжруулан боловсруулж хууль санаачлагчид уламжлан хамтран ажиллах.	2020-2021	**<u>Монголбанк</u>** Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-6 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгээс Санхүүгийн зохицуулах хороотой хамтран төслийн зөвлөхөөс өгсөн санал, зөвлөмжийг үндэслэн Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж байгаа санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоож, зохицуулагч байгууллагаас зохистой хяналт шалгалтаас гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх агуулгаар боловсруулсан болно. Хуулийн төсөл нь “санхүүгийн хэрэглэгч” буюу санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авахаар сонирхож байгаа, эсхүл авсан хувь хүн болон Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн болно. Харин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид зохицуулагч байгууллага болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, бүртгэлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэж байгаа этгээдийг хамааруулсан. Тус хууль нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо,

040

						үнэт цаас, даатгалын компаниуд, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг этгээдүүдэд хамаарна. Хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдлийг ханган 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А-1/990 дүгээр албан бичгээр хууль санаачлагч болох Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан.
				Санхүүгийн зохицуулах хороо Хуулийн төсөлд санал өгч, Монголбанктай хамтран ажиллах.		**Санхүүгийн зохицуулах хороо** 1. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр СЗХ-ноос “Санхүүгийн зохицуулах хорооны өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг боловсруулсан. СЗХ болон МБ-ны хамтарсан ажлын хэсэг нь Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулсан. Тус хуулийн төслийг 2019.12.12-ны өдөр УИХ-ын гишүүн С.Батболд болон УИХ-ын гишүүн асан Д.Дамба-Очир нар УИХ-д өргөн мэдүүлсэн ч УИХ-аас 2020.10.08-ны өдөр 28 дугаар тогтоолоор хууль санаачлагчид буцаасан. Иймд хуулийн төслийг шинээр санхүүгийн хэрэглэгчийн эрх, үүрэг, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг ба хориглох зүйл, санхүүгийн үйлчилгээнд тавигдах шаардлага ба мэдээллийн ил тод байдал, санхүүгийн үйлчилгээтэй холбоотой гомдол маргааныг шийдвэрлэх, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа, шударга бус зээллэгийн эсрэг арга хэмжээ, зэрэг харилцааг зохицуулсан 8 бүлэг бүхий төслийг боловсруулаад байна. Хуулийн төслийг Азийн хөгжлийн банкны “Санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хуулийн зохицуулалтыг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд ажиллаж буй олон улсын зөвлөхүүдэд танилцуулж, санал авсан. Мөн олон нийт, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд, холбоодын дунд хэлэлцүүлэг хийж, санал авах ажиллагаа хийсэн ба хуулийн төслийг хууль санаачлагчид хүргүүлсэн.

						3/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй буюу нээлттэй ХК-ийн нийт гаргасан хувьцааны нэг хүртэл хувийг эзэмшиж буй жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотойгоор шүүхэд нэхэмжлэл гаргах эрх хамгаалах зохицуулалтыг нэмж тусгасан. 4/ Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусгаад байна. Тухайлбал, даатгалын үйл ажиллагаатай холбоотойгоор иргэд олон нийтээс СЗХ-нд ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээлэлд боловсруулалт, судалгаа шинжилгээ хийж, даатгалын маргааныг урьдчилан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан. Дээрх хуулийн төсөлд иргэд олон нийт, холбогдох төрийн байгууллагуудаас саналыг авч, холбогдох өөрчлөлтийг оруулан, эцэслэн боловсруулаад байгаа бөгөөд хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, УИХ-ын 2024 оны намрын эээлжит чуулганаар хэлэлцүүлэх чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллаж байна. 5/ Даатгалын бодлогын зөвлөлийн 2023.04.26-ны өдрийн зөвлөлийн хуралдаанаар олон нийтийн даатгалын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр даатгалын салбарынхан хамтран ажиллах талаар зөвлөмж гаргаж, салбарын мэргэжлийн холбоодод хүргүүлсэн. Мөн салбарын хэлэлцүүлгийг 2023.03.06, 2023.04.26-ны өдөр тус тус зохион байгуулж, даатгалын салбарын оролцогчидтой санал солилцсон. СЗХ-ны даргын 2023.03.31-ний өдрийн 187 тоот тушаалаар олон нийтэд даатгалын ач тусыг таниулах, зөв ойлголт, мэдлэг, мэдээлэл түгээх сургалт, сурталчилгаа хийх ажлыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг, 188 тоот тушаалаар олон нийтийн

8/10

						даатгалын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулахтай холбоотой судалгаа хийх, санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг тус тус байгуулж, ажлын хэсгийн төлөвлөгөөг боловсруулан батлаж, хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн "Санхүүгийн зохицуулах хороо иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Санхүүгийн зах зээлийн хөгжил ба иргэдийн оролцоо" сургалт, хэлэлцүүлэг, нээлттэй хаалганы өдөрлөгийг орон нутгуудад бүсчлэн амжилттай зохион байгуулсан. Үүнд: Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Дундговь, Өмнөговь, Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор зэрэг нийт найман аймаг. Мөн СЗХ-ны үйл ажиллагаанд хамаарах үйл явдлын нийт 195 мэдээ, ээлжит хуралдааны 21 мэдээ, нийт 43 видео нэвтрүүлэг, ярилцлага, нийтлэлийг олон нийтийн мэдээллийн холбоос www.sankhuugiinbolovsrol.mn, "Ikon.mn", "Eagle.mn", "Itoim.mn" "Zarig.mn" болон СЗХ-ны цахим хуудас зэрэгт байршууллаа. СЗХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн мэдээ мэдээлэл олгох QR бүхий анонс, стенд, тараах материалыг нийт 3500 гаруй иргэдэд хүргэж ажиллалаа." 5/ Хадгаламж, зээлийн хоршооны хадгаламжийг даатгах 3 дугаар шатлалын хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэхээр Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд уг харилцааг зохицуулсан бүлэг тусгасан. Үүнд: 1. ХЗХ дампуурсан тохиолдолд хадгаламжийн даатгалын сангаас хохирлыг барагдуулах замаар санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах; 2. Тогтворжуулалтын сангийн тогтолцоог нэвтрүүлэх ингэснээр ХЗХ-ны үйл ажиллагаанд дампуурлын шинж илрэх үед туслалцаа үзүүлэх;

						3. Гишүүнчлэлтэй хадгаламж, зээлийн хоршооддоо санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх тогтворжуулалтын санг удирдах хадгаламж, зээлийн хоршоодын дундын, санхүүгийн төвлөрсөн байгууллага болох Хадгаламж, зээлийн хоршоодын нэгдсэн төвийг байгуулах; Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг баримт бичгүүдийн төслийг эцэслэн хууль санаачлагч УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн, УИХ-ын ЭЗБХ-ны дарга Ц.Цэрэнпунцаг нарт СЗХ-ны 2023.12.26-ны өдрийн 1/4922, 1/4923 тоот бичгүүдээр тус тус хүргүүлсэн.
			2.4.2.Банкны санал болгож байгаа зээлийн хугацаа, хүү, шимтгэл, хураамжийг зээлийн төрөл бүрээр харьцуулсан мэдээллийг олон нийтэд тогтмол гаргаж, банкны харилцагч, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	**Монголын банкны холбоо** Банкны зээлийн бүтээгдэхүүний нэгдсэн мэдээлэл бүхий вэбсайтыг МБ-тай хамтран бий болгож, харилцагч өөрийн хүсэж буй зээлийн хэмжээ, хугацаанд тохирсон сонголт хийх боломжийг бүрдүүлнэ. Зээлийн бүтээгдэхүүн тус бүрээр хугацааны цуваа үүсгэж, зээлийн хүү хэрхэн өөрчлөгдөж байгаа мэдээллийг харуулна.	2020-2021	**<u>Монголын банкны холбоо</u>** Банкуудын зээлийн хүүг бүтээгдэхүүн тус бүрээр түүнчлэн валютын төрлөөр харьцуулан харуулах боломжтой https://www.mongolbank.mn/loanrate вэбсайтыг Монголбанктай хамтран 2021 оны 4-р сард ажиллагаанд оруулж, эхний ээлжинд Монголбанкны сайтад байршуулсан. Банкуудаас мэдээлэл оруулах ажилтныг томилж, мэдээллийг тодорхой давтамжтайгаар тогтмол шинэчлэн ажиллаж байна. /100%/ Цаашид уг сайтыг Монголын банкны холбооны сайтад байршуулах ажил хийгдэнэ.
				Монголбанк Банк, санхүүгийн байгууллагуудын зээлийн бүтээгдэхүүний хүү, хугацаа, шимтгэлийн мэдээллийг нэгтгэж тархаах		**<u>Монголбанк</u>** Монголбанкнаас зээлийн бүтээгдэхүүний нэгдсэн мэдээлэл бүхий цахим хуудсанд (mongolbank.mn/loanrate) зориулан нэгтгэх мэдээллийн маягтыг боловсруулан Монголын банкны холбоонд хүргүүлж, банкуудаас санал авч саналыг тусгасан. Энэхүү маягтын хүрээнд

				хэлбэрийг тодорхойлж холбогдох бэлтгэл ажлыг хийх.		Монголбанкны зүгээс вэб хуудасны хөгжүүлэлтийг хийж бэлтгэн банкуудын зүгээс мэдээлэл оруулах ажилтнуудыг томилуулан тэдгээр ажилтнуудад нэвтрэх эрх, нууц үгийг хүргүүлсэн. Банкуудын зүгээс мэдээллийг оруулж байгаа бөгөөд уг мэдээлэлд Монголбанкны зүгээс хяналт тавин зарим засваруудыг оруулж байна. Эцсийн хяналтыг хийж дуусган олон нийтэд зарлана. Цаашид Монголын банкы холбооны зүгээс банкуудын мэдээллийг оруулахад хянах ажлыг хариуцан ажиллана.
				Санхүүгийн зохицуулах хороо ББСБ-уудын зээлийн бүтээгдэхүүний төрөл, хүү, шимтгэлийн талаарх мэдээллийг агуулсан мэдээллийн санг бүрдүүлэн, олон нийтэд мэдээлэх арга хэмжээг холбогдох төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах.		**<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** 1/ Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн бүтээгдэхүүн, хугацаа, хүү, шимтгэл, хураамжийн талаарх мэдээллийн загвар маягтыг боловсруулж, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоонд СЗХ-ны 2021.03.25-ны өдрийн 7/1115 тоот албан бичгийг хүргүүлсний дагуу СЗХ-ноос Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны цахим хуудаст байршуулах ажлыг мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулж, www.bbsb.mn цахим хуудаст зээлийн бүтээгдэхүүн, хүү, шимтгэл хураамжийн мэдээллийг тавьж олон нийтэд мэдээлэв. 2023 оны 3 дугаар улирлаас эхлэн Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн бүтээгдэхүүн, хугацаа, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийг СЗХ-ны www.frc.mn цахим хуудаст байршуулж, олон нийтэд мэдээлж байна. СЗХ, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой Харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэн байгуулж тус санамж бичгийн 3.2.2-т "Холбооны гишүүнчлэлийг нэмэгдүүлэх, гишүүдэд чиглэсэн үнэ төлбөргүй бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, сайжруулах", 3.2.6-д "ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн мэдээллийг өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх"-ээр тус тус тусгаж, сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Мөн

						123 ББСБ-д банк бус санхүүгийн хууль эрх зүйн орчин, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, татварын бүртгэл, тайлагналын сургалт зохион байгуулсан. 2/ Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй "Бичил санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулах" төслийн хүрээнд 2023 оны 8 дугаар сард баруун бүсийн 5 аймгийн банк бус санхүүгийн байгууллагын 34 гүйцэтгэх удирдлага, 2023.10.22-25-ны өдрүүдэд зүүн бүсийн банк бус санхүүгийн байгууллагын 30 гүйцэтгэх удирдлагад хууль эрх зүйн орчинд гарсан өөрчлөлтийн талаарх танилцуулга сургалтыг зохион байгуулсан. 3/ УИХ-ын Тамгын газраас 2024.05.18-19-ний өдрүүдэд зохион байгуулсан "Үндэсний номын баяр 2024" өдөрлөгт иргэд олон нийтэд СЗХ-ны зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгууллаа. 4/ Сангийн сайдын 2024.03.28-ны өдрийн А/49 дугаар тушаалаар "Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг шинэчилсэн батлсан. Хадгаламж, зээлийн хоршоодын хадгаламж болон зээлийн жигнэсэн дундаж хүүгийн мэдээллийг улирал бүр ХЗХ-дын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулгаар олон нийтэд мэдээлж, СЗХ-ны цахим хуудаст байршуулж байна.
			2.4.3.Барьцаалан зээлдүүлэх газар, иргэд хоорондын зээлийн үйл ажиллагааг бүртгэл хяналттай болгож, мөнго хүүлэлтийг тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох	**Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо** Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт	2020-2024	**<u>Хууль зүй, дотоод хэргийн яам</u>** Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулах Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2021 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. "Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах

				оролцож, ХЗДХЯ-тай хамтран ажиллах Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотой хязгаарлалт хийх зохицуулалтыг бүрдүүлэх.		тухай хууль"-ийн төслийг Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит нэгдсэн чуулганы хуралдаанаар батлалсан. **<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** УИХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиар барьцаалан зээлдүүлэх газар болон зээлдэгч хоорондын зээлийн гэрээний харилцаатай холбоотой зохицуулалтыг тусгасан. Барьцаалан зээлдүүлэх газар, иргэд хоорондын зээлийн үйл ажиллагааг бүртгэл хяналттай болгох зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулж, хуулийн төслийг өргөн мэдүүлэх ажлын хэсэгт ажилласан бөгөөд хуулийн төсөлд СЗХ-оос 2020.4.13, 2020.10.06, 2021.01.13-ны өдрүүдэд албан бичгээр 3 удаа санал хүргүүлж, Төрийн ордонд 2022 оны 3 дугаар сарын 01-ний өдөр УИХ-ын эдийн засгийн байнгын хороо болон төрийн байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэгт оролцож ажилласан. УИХ-ын 2022 оны хаврын чуулганаар Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг хэлэлцэхийг дэмжиж, УИХ-аас 2022 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр хуулийн төслийг батлалсан. Энэхүү хууль батлагдсанаар барьцаалан зээлдүүлэх газар болон иргэд хоорондын зээлийн үйл ажиллагаа нь бүртгэл хяналттай болж, хууль эрх зүйн орчин бүрдсэн.

						Мөн хуулиар СЗХ-нд олгогдсон бүрэн эрхийн хүрээнд СЗХ-ны 2023.03.13-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам", 82 дугаар тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бүртгэлийн дэвтэр хөтлөх, тайлан, мэдээ ирүүлэх журам", 83 дугаар тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хувийн дугаар олгох журам", 84 дүгээр тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны сургалтын журам", 85 дугаар тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн ажиллах журам"-ыг тус тус баталж, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн 2024.01.18-ны өдрийн хурлаар: -01 дүгээр тогтоолоор зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувиар тогтоох, -02 дугаар тогтоолоор "Зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загвар", - 03 дугаар тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүг бодох, тооцох аргачлал"-ыг тус тус баталсан бөгөөд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024.02.06-ны өдрийн 6594, 6595, 6596 дугаарт тус тус бүртгүүлсэн..
			2.4.4.Мөнгө хүүлэлтийг хязгаарлах зорилгоор зээлийн хүүгийн хязгаарыг тогтоох /Банк, банк бус буюу тусгай зөвшөөрлөөр зээл олгодог байгууллагуудын хүү/			**<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** 1/ УИХ-ын 2021.01.29-ний өдрийн Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар барьцаалан зээлдүүлэх газрын зээлийн хүүд тодорхой хугацаагаар хязгаарлалт тогтоосон.

						2/ УИХ-аас 2022.11.04-ний өдөр баталсан Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулиар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг Зөвлөлөөс тогтоохоор заасны дагуу Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлийн 2024.01.18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувиар, 02 дугаар тогтоолоор "Зээлийн, барьцааны, батлан даалтын гэрээний ерөнхий загвар"-ыг, 03 дугаар тогтоолоор "Мөнгөн зээлийн үйл ажиллагааны зээлийн хүүг бодох, тооцох аргачлал"-ыг тус тус баталсан бөгөөд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024.02.06-ны өдрийн 6594, 6595, 6596 дугаарт тус тус бүртгэсэн. 3/ Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 21.3-т "Зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монголбанк, СЗХ хамтран батлан, хэрэгжилтэд хяналт тавина." гэж заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгч, СЗХ-ны даргын 2023.05.23-ны өдрийн А106/298 дугаар хамтарсан тушаалаар "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал"-ыг баталсан. 4/ Банк бус санхүүгийн байгууллагын салбарын зээлийн хүү, шимтгэл хураамж, ББСБ-уудын эх үүсвэрийн өртөг, зардал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг 2022, 2023 болон 2024 оны эхний хагас жилийн байдлаар судалж, холбогдох санал дүгнэлтийг СЗХ-ны удирдлагуудад танилцуулсан.
		2.5.1.Зээлийн мэдээллийн санд бүх төрлийн санхүүгийн байгууллагын зээлтэй холбоотой мэдээллийн	**Монголбанк** ОУВС, ОУСК-иас өгсөн зөвлөмжийн дагуу олон улсын стандарт шаардлагад	2020-2021	**<u>Монголбанк</u>** -Монголбанкны зүгээс програм хангамж худалдан авах санхүүжилтийн эх үүсвэрийн талаар Азийн хөгжлийн банктай 2021.01.18, 26-ны өдөр хамтарсан уулзалт

		2.5.Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, зээлдэгчийн эрсдэлийг бодитой үнэлэх нөхцөлийг бүрдүүлэх	агуулгыг өргөжүүлж, олон улсын жишигт нийцсэн программ хангамжийг ашиглах	нийцсэн зээлийн мэдээллийн сангийн програм хангамжийг худалдан авах санхүүжилтийн эх үүсвэрийг Сангийн яамтай хамтран шийдвэрлүүлэх.		хийсэн. Өмнө нь Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр олон улсын стандарт шаардлагад нийцсэн програм хангамж худалдан авах саналыг 2020 оны 9 дүгээр сард холбогдох танилцуулгын хамт Монгол Улсын Сангийн яаманд хүргүүлсэн. Азийн хөгжлийн банкны зүгээс 2022 оноос хэрэгжүүлэх хөтөлбөрт тусгах замаар шийдвэрлэх боломжтой талаар мэдэгдээд байна. - Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн талаар баримтлах бодлого болон төсвийн талаар дэлгэрэнгүй танилцуулгыг 2020.11.05-ны өдөр боловсруулав. - Энэхүү стратеги төлөвлөгөө батлагдсанаас хойш Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээг 10 ББСБ, 5 ХЗХ, 3 үнэт цаасны компаниуд, 3 төрийн байгууллага зэрэг нийт 21 гэрээг байгуулан ажилласан. -Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор "Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийн 2021 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүлээн авах тухай мэдээлэл"-ийг 2021.01.15-ны өдөр Монголбанкны цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдэгдсэн. Одоогийн байдлаар нэг аж ахуйн нэгж холбогдох материалыг ирүүлсэн байгаа бөгөөд 2021.06.01-ний өдөр нэгдсэн журмаар хүсэлт хүлээн авах ажиллагааг дуусгавар болгож, шийдвэрлэх арга хэмжээ авахаар хүлээгдэж байна. - Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А-202 дугаартай тушаалаар батлагдсан Зээлийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгээс хуулийн төслийн хэрэгцээ,

						шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг боловсруулж дуусгасан.
				Санхүүгийн зохицуулах хороо ББСБ-уудыг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах		**<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** Монголбанкнаас зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчийн операторын эрхийг "Титан си ар" ХХК, "Бүрэн скор" ХХК-д тус тус олгосонтой холбогдуулан 2024 оны 2 дүгээр улирлын байдлаар зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 486 ББСБ-ын 95.4 хувь буюу 464, 183 ХЗХ-ны 59.0 хувь буюу 109 ХЗХ ББСБ Монголбанк, "Бүрэн скор ЗМС" ХХК болон "Титан Си Ар Эй ЗМС" ХХК-ийн аль нэгтэй гэрээгээ шинэчлэн байгуулж, мэдээллээ нийлүүлж байна.
			2.5.2.Зээлийн мэдээллийн сан болон төрийн эрх бүхий байгууллагын мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох боломжийг бий болгож, мэдээллийн сангийн найдвартай байдлыг сайжруулж, ашиглалтыг нэмэгдүүлэх	**Монголбанк, Засгийн газар** Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх протоколыг шинэчилэх. E-mongolia цахим портал, ХУР мэдээлэл солилцооны системээр дамжуулан зээлийн мэдээллийн лавлагааг иргэд, аж ахуйн нэгжид өгдөг болох.	2020-2021	**<u>Монголбанк</u>** - Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийн баазад мэдээлэл нийлүүлэх протоколыг шинэчлэн , МБЕ-ийн 2024.03.15-ны өдрийн А-31 дүгээр тушаалаар батлуулсан. - Татварын ерөнхий газартай "Мэдээлэл солилцох гэрээ"-г 2020.10.06-ны өдөр байгуулсан бөгөөд гэрээний хүрээнд мэдээлэл солилцох бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна. Мөн Мэдээллийн ил тод байдлын тухай хуульд шинэчлэн батлагдсантай холбогдуулан тус хуулийн 37.2 дахь заалтын дагуу Үндэсний дата төв болон Монголбанк хооронд хийгдсэн 2020 оны 1720/810 дугаартай "Төрийн мэдээлэл солилцооны систем ашиглах гэрээ"-г шинэчлэн байгуулах талаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас мэдэгдсэний дагуу тус яамтай 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Үндсэн систем (Хур)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан болно. E-mongolia цахим порталаас иргэд, аж ахуйн нэгжид зээлийн мэдээллийн лавлагааг авах боломжтой болсон.

						Хууль зүй, дотоод хэргийн яам -Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль (шинэчилсэн найруулга) 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар батлагдаж 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд уг хуулиар цахим баримт бичиг, цахим албан хэрэг хөтлөлт, архивын цахим мэдээллийн санг үүсгэхтэй холбогдсон харилцаан уламжлалт албан хэрэг хөтлөлт, бичиг баримт, архивтай хослуулан зохицуулна. Мөн үүнтэй холбогдуулан Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт (шинэчилсэн найруулга) оруулах тухал хуулийн төслийг боловсруулж байна. -Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл, Нийтийн мэдээллийн тухай хуулийн төслийн УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа.

			2.5.3.Банкны зээлийн эрсдэлийн судалгааг сайжруулж, зээлдэгчийн зээлийн эрсдэлийн үнэлгээг хийх бие даасан институцийг хувийн хэвшилд суурилан байгуулах	**Монголбанк, Засгийн газар** Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан төрийн байгууллагын мэдээллийг зээлийн мэдээллийн санд нийлүүлэх ажлыг зохион байуулах. Монголбанкны зээлийн мэдээллийн сан /олон нийтийн зээлийн мэдээллийн сан/ болон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн компани /зээлийн мэдээллийн товчоо /-ийн үйл ажиллагаа, эрх үүргийг тодорхой болгох зорилгоор Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, хууль санаачлагчтай хамтран ажиллах.	2020-2024	**<u>Монголбанк</u>** - Монголбанкнаас Зээлийн мэдээллийн тухай хуулийн дагуу Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хуульд заасан шаардлага хангасан 2 этгээдэд олгосон. - Зээлийн мэдээллийн тухай хуулийг шинэчлэх хуулийн төслийн санал боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан хуулийн төслийг олон улсын чиг хандлага, стандартад нийцүүлэх ажлыг Дэлхийн банктай хамтран гүйцэтгэж байна. Тус ажлын хүрээнд Ажлын хэсгээс зээлжих зэрэглэлийг тогтоох зорилго бүхий зээлдэгчийн зээлийн эргэн төлөлт зэрэгт үндэслэсэн оноог тооцох (кредит скоринг) тогтолцоог нэвтрүүлэх банк эрх бүхий этгээдийн зээлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу шаардлагатай судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулж дуусаад байна..

3	**Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах**	3.1.Банк, санхүүгийн салбарт санхүүгийн технологи, цахим шилжилтийг эрчимжүүлэн үр ашгийг нэмэгдүүлэх	3.1.1.Технологийн дэвшлийг санхүүгийн салбарын үйлчилгээнд ашиглах ажлыг эрчимжүүлэх	**Монголбанк** Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний АСН системд дансны нэгдсэн санг нэвтрүүлж утасны дугаар болон бусад мэдээллээр гүйлгээ илгээх боломжийг бүрдүүлэх; **Монголбанк, Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо** - Харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг цаг алдалгүй тогтоох зорилгоор мэдээллийн эх үүсвэр (УБЕГ-ын мэдээллийн сан гэх мэт)-т банк, санхүүгийн зохицуулагч байгууллага болон банк, санхүүгийн байгууллага хандах эрх бүхий дэд бүтцийг бий болгох талаар холбогдох судалгаа хийж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал боловсруулах; - Big data буюу их өгөгдлийг боловсруулах, AI буюу хиймэл оюун ухааны тусламжтайгаар мэдээллийн боловсруулалт хийх замаар харилцагчийн онцлог, хэв маягт тохирсон оновчтой санхүүгийн	2020-2024	**Монголбанк** - Дансны нэгдсэн санд 11 сая ширхэг дансны мэдээлэл одоогоор бүртгэгдсэн байгаа бөгөөд тухайн дансны мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн газар, банкууд ашиглан гүйлгээ илгээж байгаа. Цаашдаа гар утасны дугаарыг Дансны нэгдсэн санд бүртгүүлснээр зөвхөн гар утасны дугаар ашиглан гүйлгээ илгээх хүлээн авах боломжийг нээхээр банкуудтай хамтран ажиллаж байна. -Дебит гүйлгээний системийг ашиглахад бэлэн болсон бөгөөд одоогоор Хаан банк, Мобиком байгууллагууд нэвтрүүлэхээр тест, туршилтын ажил хийгдэж байна. - Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А-1 тоот тушаалаар QR кодын мессежийн бүтэц, зааврыг баталсан бөгөөд тус тушаалыг 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн нийт банкууд, төлбөрийн системийн оролцогчид үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана. Ингэснээр QR код ашиглан хийх жижиглэнгийн төлбөр тооцоо улам хялбар, хүртээмжтэй болж, бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээ нэмэгдэж, зардал буурах юм. -Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар батлагдсан бөгөөд уг хуулиар банк, эрх бүхий хуулийн этгээдээс цахим хэлбэртэй үйлчилгээнд тухайн банк, эрх бүхий хуулийн этгээдэд данстай, санхүүгийн тогтвортой харилцаа үүсгэсэн этгээдийн бүртгэлтэй баталгаат цахим шуудан, эсхүл техникийн хэрэгсэл, программ хангамж, нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, тоон гарын үсэг зэргийг

				зуучлагчийн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх, холбогдох хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчинг бий болгох талаар холбогдох судалгаа хийж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал боловсруулах; - Үйлчилгээний болон холбогдох зардлыг бууруулах, аюулгүй байдлыг хангах зэрэг зорилгоор шинэ технологид суурилсан төлбөрийн болон бусад системийг хөгжүүлэх, Үүлэн технологийг нэвтрүүлэх талаар холбогдох судалгаа хийж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох санал боловсруулах; -ББСБ-уудын салбарт технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох.		ашиглан гаргасан саналыг банк, эрх бүхий хуулийн этгээд хүлээн авсан бол Иргэний хуулийн 42[1] дүгээр зүйл, 196.1-д заасантай адилаар хэлцэл хийсэн, гэрээ байгуулсанд тооцохоор зохицуулсан. -Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-д банк, эрх бүхий этгээдээс харилцагчтай цахим хэлцэл хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан. **<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** 1/ Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж буй 28 үнэт цаасны компани өөрийн цахим сайт, аппликейшнээр дамжуулан бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг хэрэглэгчдэд хүргэж, цахимаар үнэт цаасны данс нээх боломж бүрдүүлсэн. 2/ Даатгалын салбарын үйл ажиллагааны улирлын нэгдсэн тайланд цахим даатгалтай холбоотой мэдээллийг оруулсан. Мөн уг мэдээллийг тогтмол авах зорилгоор Даатгалын багц дүрмийн 11 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан. Тогтоолын төсөлд даатгалын салбарын оролцогчид болон олон нийтээс санал авахаар СЗХ-ны цахим хуудаст байршуулан, улмаар 2023.07.06-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, журамд өөрчлөлт оруулах төслийг эцэслэн боловсруулсныг СЗХ-ны 2023 оны 741 дүгээр тогтоолоор батлсан. Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүрийн утгыг шинэчилж хуульд заасан үндсэн 9 итгэлцүүрийн хамрах хүрээнд илтгэлцүүрүүдийн утгыг Олон улсын сайн туршлагын дагуу өргөжүүлж, жолоочийн даатгалын мэдээллийн санд нийлүүлэх мэдээллийн хүрээг нэмэгдүүлж, статистик тооцооллоос динамик тооцоолол руу шилжих, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаанд

						түлхүү технологид суурилсан үйлчилгээг ашиглах, хиймэл оюун ухааны тусламжтай даатгуулагчийн шинж чанар, эрсдэлийг тооцоолох зохицуулалтыг тусгасан журмын төслийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу олон нийтээс санал авахаар СЗХ-ны цахим хуудаст байршуулан, даатгалын салбарын оролцогчдыг хамруулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, олон нийтээс санал авсан. Улмаар төслийг эцэслэн боловсруулж, СЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Даатгалын үйл ажиллагаанд цахим болон аливаа дэвшилтэт техник, технологийг ашиглах зохицуулалтыг сайжруулах хүрээнд холбогдох судалгааг хийж, Даатгалын багц дүрмийн 1 дүгээр хавсралт "Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж, олон нийтээс санал авахаар СЗХ-ны цахим хуудаст байршуулсан. Даатгалын багц хуулийн төсөлд даатгалын үйл ажиллагааг цахим технологи ашиглан зохион байгуулах, даатгалын гэрээний болон бусад харилцаанд биометрик мэдээлэл ашиглах зэрэг технологийн дэвшилтэй холбоотой суурь зохицуулалтуудыг тусгаж Засгийн газрын хуралдаанд танилцуулан УИХ-ын 2024 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллаж байна. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар цахим даатгалын үйлчилгээ нийт даатгалын үнэлгээний 0.6 хувийг, даатгалын нийт хураамжийн орлогын 4.9 хувийг, нийт даатгалын нөхөн төлбөрийн 5.2 хувийг, нийт байгуулсан даатгалын гэрээний 17.3 хувийг тус тус эзэлж байна. 3/ СЗХ-ны 2020 оны 495 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт

						тавих журам”-д цахим систем ашиглаж гадаад валютын арилжаа эрхлэх тохиолдолд ISO/IEC 27001 стандартыг хангаж ажиллахаар эрх зүйн зохицуулалтыг тусган уг нэмэлт өөрчлөлтийг оруулж, СЗХ-ны 2023.06.23-ны өдрийн 220 дугаар тогтоолоор батлсан. Технологид суурилсан зээлийн бүтээгдэхүүн гаргаж буй банк бус санхүүгийн байгууллагуудад СЗХ-ны 2022 оны 160 дугаар тогтоолоор батлсан “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-д ISO стандартын шаардлага хангах зохицуулалтыг тусгасан бөгөөд нэр бүхий 56 ББСБ-ууд СЗХ-ны дэргэдэх Цахим зөвлөлөөс холбогдох зөвшөөрөл авч, ISO стандартын шаардлагыг нэвтрүүлэн зах зээлд үйлчилгээ үзүүлж байна. Зээлдэгчийг өрийн дарамтад орохоос сэргийлэх зорилгоор СЗХ-ны 2022 оны 527 дугаар тогтоолоор финтек зээлийн бүтээгдэхүүний өр/орлогын харьцааг 70 хувиас ихгүй байхаар тогтоосон. 4/ Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн тайлан мэдээг өдөр бүр тогтмол авах API системийг дотооддоо хөгжүүлэн vaspapi.frc.mn-р дамжуулан авдаг болсон. Ингэснээр тухайн салбарын нийт арилжаа, үнэлгээ болон хэрэглэгчдийн тоог бодит цагийн горимоор хянах боломжтой болсон. 5/ АХБ-ны дэмжлэгтэйгээр СЗХ-ны хэрэгжүүлж буй “Монгол Улсад финтек салбарын хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх мэргэжлийн болон техник туслалцааны хөтөлбөр” /Knowledge and Support Technical Assistance on Developing Fintech Legal and Regulatory Frameworks for Mongolia/-ийн хүрээнд Монгол Улсын финтек салбарыг судлахаар төслийн зөвлөх баг 2024.03.25-29, 2024.06.10-14-ний одрүүдэд Монгол Улсад ажиллаж, салбарын өнөөгийн нөхцөл байдлыг судлах, зөвлөмж болон замын зургийн ерөнхий агуулгыг салбарын оролцогчдод танилцуулж, санал солилцох

						уулзалтыг зохион байгуулсан. Төслийн багаас финтекийн салбарыг хөгжүүлэх замын зураг, болон суптекийг нэвтрүүлэх зөвлөмжийн төслийг СЗХ-нд ирүүлсэн бөгөөд газар, нэгжүүдээс санал авахаар хүргүүлсэн. 6/ Технологид суурилсан санхүүгийн шинэ төрлийн үйлчилгээний зохицуулалтын нэг хэлбэр болох сэндбокс зохицуулалтын орчинд 2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 23 компани өөрсдийн хөгжүүлж буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндбокс орчинд турших хүсэлтээ ирүүлснээс 8 компани сэндбокс орчинд орсон. 7/ ҮХХЗБ нь үл хөдлөх хөрөнгийн дуудлага худалдаан цахим хэлбэрээр зохион байгуулах, орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийн талбайг хэсэгчлэн худалдан борлуулах, үл хөдлөх хөрөнгийг хөлслүүлэх, түрээслүүлэх үйлчилгээг цахим платформоор зуучлах технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэн ажиллаж байна.

			3.1.2.Зээлийн, барьцааны, даатгалын зэрэг гэрээ, хэлцлийг цахимаар хийж, баталгаажуулах агуулгаар Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	**Монголбанк, Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо** - Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах; -Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон эрх орчинг бүрдүүлэх чиглэлээр судалгаа хийж санал боловсруулах. -Цахим архив, цахим нотлох баримт бүрдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх санал боловсруулах.	2020-2024	**<u>Монголбанк</u>** -Дебит гүйлгээний системийг ашиглахад бэлэн болсон бөгөөд одоогоор Хаан банк, Мобиком байгууллагууд нэвтрүүлэхээр тест, туршилтын ажил хийгдэж байна. -Монголбанкнаас тоон гарын үсгийг санхүүгийн хэрэглэгчдэд олгож, төлбөр тооцоо, санхүүгийн бүх төрлийн үйлчилгээнд ашиглаж болох тухай өөрчлөлтийг Цахим гарын үсгийн тухай хуульд оруулахаар санал боловсруулж хүргүүлсэн. Санал УИХ-аар дэмжигдээгүй болно. **<u>Засгийн газар:</u>** Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төслүүдийг Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д 2021 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн ЗГ-1/65 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн. Хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан. **<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** 1/ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд банк бус санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэх тохиолдолд зээлийн гэрээнд тоон гарын үсгээр баталгаажуулах, харилцагчийг зайнаас таньж мэдэх зорилгоор дэвшилтэт технологи ашиглах боломжтой байхаар зохицуулсан бөгөөд УИХ-ын 2022.05.20-ны өдрийн хаврын ээлжит чуулганы хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэхээр шийдвэрлэж, ЭЗБХ-нд шилжүүлсэн. УИХ-ын ЭЗБХ-ны даргын 2022.05.31-ний өдрийн 06 тоот тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн

						шинэчилсэн найруулгын төсөл" болон хамт өргөн мэдүүлэх хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий СЗХ-ны дотоод ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 2023 оны 11 дүгээр сард 3 удаа хуралдаж, хуулийн төслийг ЭЗБХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. УИХ-ын 2021.05.21-ний өдрийн хуралдаанаар баталсан Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлд банк, эрх бүхий хуулийн этгээдээс цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг, Иргэний хуулийн 421 дүгээр зүйлд цахим хэлбэрээр хийх хэлцлийн зохицуулалтыг тусгасан. 2/ Даатгалын багц хуулийн төсөлд даатгалын гэрээг цахимаар хийх боломжийг олгосон зохицуулалтуудыг тусгахаас гадна Даатгалын тухай хуулийг дагаж гарах Монгол Улсын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд даатгалын гэрээг цахимаар хийх боломжийг олгосон заалтыг тусгасан. 3/ Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд хадгаламж, зээлийн гэрээг цаг үеийн чиг хандлагад нийцүүлэн цахим хэлбэрээр байгуулах боломжийг олгох зохицуулалтыг тусгасан
			3.1.3.Төлбөрийн карт уншигч, бэлэн мөнгөний автомат машины нэгдсэн стандарт тогтоож, үйл ажиллагааны зардлыг бууруулах	**Монголбанк** Үндэсний брэнд төлбөрийн ₮ картыг олон улсын EMV стандартын чип технологид шилжүүлэх, Үндэсний брэнд төлбөрийн ₮ картыг зайнаас унших (contactless) технологитой болгох.	2020-2021	**<u>Монголбанк</u>** • Монголбанк нь үндэсний брэнд төлбөрийн ₮ картыг EMV стандартын чип технологид шилжүүлэх ажлын хүрээнд олон улсын Мастеркарт байгууллагатай хамтран ажиллаж байна. Төлбөрийн картын гаргаж байгаа бүх байгууллагууд нь EMV чип технологид шилжих системийн хөгжүүлэлтийг амжилттай хийж дуусгасан бөгөөд 2021 оны 10 дугаас сарын 01-

						ний өдрөөс эхлэн EMV чип бүхий картыг зах зээлд гаргаж эхэлсэн. • EMV чип бүхий ₮ карт нь шууд зайнаас унших технологитой бөгөөд зайнаас уншуулсан ₮50,000 хүртэл үнийн дүнтэй гүйлгээнд ПИН код оруулах гэх мэт ямар нэгэн баталгаажуулалт шаардахгүй. • 2021 оны 12 сарын байдлаар нийт ₮ картын 17 орчим хувь нь EMV чип технологид шилжсэн байгаа. Бүх ₮ картыг 2024 он гэхэд 100% чип технологид шилжүүлэн дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.
				Монголын банкны холбоо Бэлэн мөнгөний нэгдсэн удирдлагын төв байгуулах төсөл хэрэгжүүлж, салбарын зузаатгал, АТМ цэнэглэлтэд давхардан гарч буй зардлыг бууруулах, ПОС төхөөрөмжийн давхардлыг арилгах боломжийг эрэлхийлж, банкууд болон финтек компаниудын хамтын ажиллагааг дэмжих, гүйлгээний мэдээллийг цахимаар илгээх замаар ПОС төхөөрөмжийн цаасны хэрэглээг бууруулах		**<u>Монголын банкны холбоо</u>** • Бэлэн мөнгөний нэгдсэн удирдлагын төв байгуулах төсөл хэрэгжүүлж, салбарын зузаатгал, бэлэн мөнгө тоолох, АТМ цэнэглэлтэд давхардан гарч буй зардлыг урт хугацаанд бууруулж үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах зорилготой төсөл 2020 оноос хойш албажин, төслийн хэлбэрээр хэрэгжиж байна. • Энэ санаачлага төслийг МБХ дангаараа хэрэгжүүлэхэд санхүүгийн нөөц бололцоо, энэ чиглэлийн туршлага байгаагүй тул ОУ-д бэлэн мөнгөний менежментээр мэргэшсэн үйлчилгээ үзүүлэгч Бринкс ХХК-г төслийн хүрээнд банкуудаас тоон мэдээлэл авч дүн шинжилгээ хийн, Бринксийн бэлэн байгаа зохион байгуулалт дээр суурилан банкуудын бэлэн мөнгөний удирлага үйл ажиллагааг цогцоор нь шилжүүлэх тохиолдолд банкуудад санал болгох үнийн санал, төслийн үе шатыг схемчлэх зэрэг гол ажлуудыг өөрсдийн санхүүжилтээр хийж гүйцэтгэх чиг үүрэг өгч, манай холбооноос банкуудын холбогдох газар нэгжтэй харилцаа холбоо

						тогтоох, дундын зохицуулалтыг хийж ажиллахаар болсон. • Өнгөрсөн онд энэхүү санаачлага төсөл маань дараагийн шатанд гарч, Бринкс Монгол ХХК-аас банкуудын бэлэн мөнгөний удирдлагыг шилжүүлэн, өөрсдийн туршлага, бусад нөөцийг тооцоолж, тоон мэдээлэл гаргаж хамтран ажилласан системийн 3 том банкинд урьдчилсан байдлаар үнийн санал бэлтгэн хүргүүлсэн. Үнийн санал, тооцооллыг хянах, дүгнэлт гаргах зэрэг хөндлөнгийн дүн шинжилгээ хийлгэж, банкуудад үйл ажиллагаагаа шилжүүлж эхлэх, outsourcing хийх шийдвэр гаргахад хэрэгтэй дүгнэлт санал боловсруулах хэрэгцээ шаардлагатай болсон. Энэ ажлыг МБХ-ны Гүйцэтгэх захирал Л.Амар өнгөрсөн оны 2-р хагаст санаачлан, холбооноос бие даасан зөвлөх, шинжээч хөлсөлж ажиллуулах, тус зардлыг гишүүн банкууд хуваан, нэхэмжлэхийн дагуу шилжүүлэх шийдвэр гаргуулсан. Үүний дагуу бид хөндлөнгийн шинжээчийг гэрээлэн, банкуудын удирдлагад шийдвэр гаргахад нь хөндлөнгөөс дүгнэлт, зөвлөмж өгүүлэхээр ажиллуулав. • Шинжээчийн дүгнэлт бэлэн болж банкуудын шийдвэр гаргах түвшний удирдлагад тодорхой шат дамжлагатайгаар дүгнэлт танилцуулах ажил 2021 онд хийгдэв. МБХ-ны Удирдах зөвлөлөөс ямар нэг эсэргүүцсэн санал гараагүй болно. • Энэ оны эхээр ажлын хэсгийг хуралдуулж 3 банк эхний ээлжинд бэлэн мөнгөний удирдлагаа нэгтгэх ажлыг хэрхэн яаж зохион байгуулах төлөвлөгөөг гаргахаар байна.
				Засгийн газар	2020-2021	**Засгийн газар**

		3.2.Банк, санхүүгийн байгууллагаас авдаг шимтгэл, хураамжийн төрөл, хэмжээг багасгах	3.2.1.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай, Зээлийн мэдээллийн тухай, Өрсөлдөөний тухай, Татварын багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх			Монгол Улсын Их Хурлын "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын 4.2-д заасан " ... Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэнд аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулах." зорилтын хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2022 оны 04 сард нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд дараах нэмэлт, өөрчлөлтүүд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байна. Үүнд: 1. 2023 оноос хойш хэрэгжих дулаан, цахилгааны төслүүд борлуулалт хийж эхэлснээс хойш гурван жил 90 хувь, дараагийн гурван жил 50 хувиар тус тус орлогын татвараас хөнгөлнө. 2. Уул уурхайн лиценз эзэмшдэггүй компани нийслэлд байршилтай (Багануур, Багахангай, Налайх дүүргээс бусад дүүрэгт байршилтай) үйлдвэр, агуулахаа орон нутагруу нүүлгэсэн тохиолдолд нүүлгэн, шилжүүлэлтийн зардлыг 50 хувиар нэмэгдүүлэн тооцож татвар ногдох орлогоос хасна. 3. Уул уурхайн лиценз эзэмшдэггүй компанийн орон нутагт барьж байгуулсан барилга байгууламжийн элэгдэл тооцох хугацаа одоо 25 жил байгааг өөрийн сонголтоор 15 жилийн дотор түргэн хугацаанд элэгдүүлэн зардлаа хурдан нөхөх боломж олгоно. 4. Уул уурхай лиценз эзэмшдэгээс бусад орон нутагт үйл ажиллагаа явуулдаг, орон нутагт бүртгэлтэй компани ажил хайгч иргэнийг шинээр ажилд авч ажиллуулсан тохиолдолд олгосон цалингийн зардлыг 20 хувиар нэмэгдүүлэн тооцож, татвар ногдох орлогоос нэг удаа хасч татварын дэмжлэг үзүүлнэ. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үнэт цаасны зах зээл, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, бизнесийн орчныг дэмжих, татварын хөнгөлөлт эдлүүлэх, шаталсан

						татварын тогтолцоог нэвтрүүлэх, цахим төлбөрийн баримтын тогтолцоог өргөжүүлэх зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж 2023 оны төсвийн төслийг дагалдуулан батлууллаад байна. Энэ хуулийн хүрээнд хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгийн зах зээлийн таатай орчныг бий болгох бодлогын хүрээнд дараах өөрчлөлтүүдийг тусгасан. Үүнд: - Үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагдах ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй компанийн хувьцааны ногдол ашгийн суутган татварыг 5 хувь болгох; - Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх; - Хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгохтой холбоотой зардлыг тодорхой хувиар өсгөж тооцон татварын хөнгөлөлт үзүүлснээр хөрөнгийн зах зээл идэвхжиж, санхүүгийн зах зээлийн төвлөрөл буурах; - Инновацын тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацын бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш 3 жилийн хугацаанд бүрэн хөнгөлөлт үзүүлж байгааг 5 жил болгож сунгах; Программ хангамж боловсруулах, хөгжүүлэх үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн үндсэн үйл ажиллагаанд ашиглах программ хангамжийн эрхийн шимтгэл, сервер түрээслэх төлбөрийг Монгол Улсад байрладаггүй этгээдэд шилжүүлсэн орлогод ногдуулах албан татварын хувь хэмжээг бууруулах зэрэг болно. Ийнхүү хөрөнгө оруулалтыг дэмжсэн татварын

						бодлого хэрэгжүүлснээр зээлийн хүүг бууруулахад дэмжлэг болно гэж үзэж байна.
				Монголбанк Монголбанкны ажил үйлчилгээний ерөнхий нөхцөлд тусгасан, банкны эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, банкны нэгж байгуулах тусгай зөвшөөрлийн шимтгэлд өөрчлөлт оруулах.		**<u>Монголбанк</u>** Монголбанкны ажил үйлчилгээний ерөнхий нөхцөлд тусгасан, банкны эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, банкны нэгж байгуулах тусгай зөвшөөрлийн шимтгэлд өөрчлөлт оруулж Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар хураамжийн төлбөрийг “0” болгохоор шийдвэрлэсэн.
				Санхүүгийн зохицуулах хороо Ажлын хэсэгт орж, санал өгч хамтран ажиллах.		**<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** Монголын даатгалын холбоотой хамтран 2023.06.06-ны өдөр зохион байгуулсан “Даатгалын салбарыг татварын бодлогоор дэмжих нь” сэдэвт уулзалт хэлэлцүүлэгт даатгалын салбарын төлөөлөл оролцож, даатгалын салбар дахь өнөөгийн татварын хууль эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудлууд болон түүнийг шийдвэрлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж, санал солилцсон. Түүнчлэн даатгалын салбарт тулгамдаж буй татварын хууль, эрх зүйн орчны талаар судалж, даатгалын салбар дахь татварын хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр санал боловсруулж, саналыг УИХ-ын дэргэдэх Төсвийн байнгын хороо, ЭЗБХ болон Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. Тухайлбал, даатгуулагч аж ахуйн нэгж байгууллагын хохирлыг нөхөн төлөхөөр шилжүүлж буй даатгалын нөхөн төлбөрөөс татвар авч байгаагаас даатгуулагч тэр хэмжээгээр хохирлоо буцаан сэргээх боломжгүй болж, хохирч байгаа тул уг заалтыг хасах, мөн олон улсын давхар даатгагчид шилжүүлж буй давхар даатгалын хураамжид татвар суутган тооцохгүй байх зэрэг даатгагч болон даатгуулагчийн хувьд эрсдэлийн

						удирдлага хэрэгжүүлэн аливаа эрсдэлийг даатгалын тусламжтайгаар бууруулах, томоохон хэмжээний хохирлоо даатгалын тогтолцоонд шилжүүлэхэд хязгаар тавьсан зохицуулалтуудыг хасах, нөгөө талаас дотоодын даатгалын салбарыг хөгжүүлэхэд дэмжлэг болох зохицуулалтуудыг бүрдүүлэхээр санал хүргүүлсэн.
4	**Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах**	4.1.Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж, дэмжих	4.1.1.Холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	**Татварын ерөнхий газар** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудын холбогдох заалтуудад үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлж дэмжих зорилгоор дараах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг, ажлын хэсгийн шийдвэр, Хөрөнгийн бирж, ҮЦТХТТ, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллагын мэдээлэлд хийсэн тооцоо судалгаанд үндэслэн боловсруулах ажлын хэсэгт ажиллах; 1.Гаднын хөрөнгө оруулагчийг татах зорилгоор оршин суугч бус болон МУ-д байрладаггүй татвар төлөгчийн Монгол Улсын хөрөнгийн зах зээлээс худалдаж авсан хувьцааны ногдол ашиг	2020-2021	**<u>Монголбанк</u>** Монголбанкны ажил үйлчилгээний ерөнхий нөхцөлд тусгасан, банкны эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, банкны нэгж байгуулах тусгай зөвшөөрлийн шимтгэлд өөрчлөлт оруулж Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар хураамжийн төлбөрийг" 0" болгохоор шийдвэрлэсэн. УИХ-ын гишүүн Б.Баттөмөрийн УИХ-д өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах чиг үүрэг бүхий УИХ-ын гишүүн Г.Амартүвшингээр ахлуулсан ажлын хэсгийн дэд ажлын хэсэгт ажиллаж Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр батлагдаж 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

				болон хувьцаа борлуулсны орлого, нээлттэй арилжаалах бондын хүүгийн орлогын нийт дүнгээс 20 хувиар албан татвар ногдуулж байгааг бууруулах, зардал хасах боломж үндэслэлийг судлах 2.Хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүнүүдэд хамааралтай татварын албан татвар ногдуулах харилцааг ойлгомжтой болгож, холбогдох журам болон түүнд өөрчлөлт оруулах боломжтой эсэхийг судлах; 3.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг УИХ-д өргөн барихтай холбоотойгоор хөрөнгийн зах зээл болон хөрөнгө оруулалтыг дэмжих зорилготойгоор татварын бодлогыг тодорхойлж, түүний хөрөнгийн зах зээл, төсвийн орлогод хэрхэн нөлөөлөхийг судлах ; 4.Хөрөнгө оруулалтын менежментийн компани болон хөрөнгө оруулалтын сангийн орлогыг 2020 он хүртэл татвараас чөлөөлж байсан нөлөөллийг судалж,		

				цаашид хувийн хөрөнгө оруулалтын сан болон нийтийн хөрөнгө оруулалтын сангийн орлогод ялгавартай татварын бодлогоор нээлттэй хөрөнгийн зах зээлийг дэмжих, татвараас зайлсхийх боломжийг хаах талаар судалж, гаргах; 5.Дотоодын компани нээлттэй хувьцаат компани болж IPO гаргахад гарсан зардлыг ААНОАТ ногдох орлогоос хасч тооцох зохицуулалт оруулах шаардлагатай эсэхийг судлах; 6.Олон улсад ашигладаг урт хугацаанд хөрөнгө оруулалтаа хадгаладах үеийн татварын хөнгөлөлт үзүүлэх механизмийг судлах;		
				Санхүүгийн зохицуулах хороо -Үнэт цаасны бүртгэл, арилжааны шимтгэл, хураамжийн судалгаа хийх, дүгнэлт гаргах, дэд бүтцийн байгууллагуудын системийг шинэчлэх, шимтгэл, хураамж		**Санхүүгийн зохицуулах хороо** 1/ Үнэт цаасны арилжааны шимтгэл, хураамжийг бууруулж, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, зах зээлд оролцогчдыг дэмжихтэй холбогдуулан бодлого, зохицуулалтын дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн: • 2020 онд "ҮЦТХТ" ХХК нь анхдагч зах зээл дэх арилжааны шимтгэл 0.24 хувь байсныг 50 хувиар бууруулж 0.12 хувь болгосон.

				бууруулах санал боловсруулах; - Хөрөнгийн зах зээлийн оролцогч талуудын татварын төрөл болон төлөлтийн талаарх мэдээлэл цуглуулах, олон улсын туршлагыг судлан, дүгнэлт гаргаж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал боловсруулж, хууль санаачлагчид уламжлах.		• 2020 онд "МҮЦКТ" ХХК-ийн хоёрдогч зах зээлийн арилжааны шимтгэлийг хэлцэл тус бүрээс 0.12 хувь болгон 50 хувиар бууруулсан. • "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-д хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх бүртгэх үйлчилгээний хөлс нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 1 хувь байсныг нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн хэмжээнээс хамааруулан хязгаар тогтоож, 50-75 хувиар бууруулан 0.25-0.5 хувь болгосон. Мөн жилийн үйлчилгээний хөлсний хэмжээ сангийн цэвэр хөрөнгийн дүнгийн 0.1 хувь байсныг 50 хувиар бууруулж 0.05 хувь болгосон. • "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Бүртгэлийн журам"-д хувьцааг бүртгэх үйлчилгээний хөлс нийт бүртгүүлсэн үнийн дүнгийн 0.1 хувь байсныг үнийн дүнгээс хамааруулан 20-40 хувиар бууруулан 0.06-0.08 хувь болгосон. Мөн өрийн хэрэгсэл бүртгэх үйлчилгээний хөлс үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлбэл зохих мөнгөн хөрөнгийн 0.1 хувь байсныг үнийн дүнгээс хамааруулан 0-36 хувиар бууруулан 0.064-0.1 хувь болгосон. • "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Арилжааны журам"-д хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжаанд худалдсан тал шимтгэлгүй байх, түүнчлэн худалдан авсан талын хувьд хэлцлүүдийн үнийн нийлбэр дүнгээс хамааруулан шимтгэлийг тооцдог байхаар зохицуулалтыг тусгаж СЗХ-ны даргын 2022.06.21-ний өдрийн 335 дугаар тушаалаар батламжлуулсан. • Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагчид /брокер/-аас СЗХ-нд төвлөрүүлэх зохицуулалтын

						үйлчилгээний хөлсийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалагдсан угаасан болон самнасан ноолуурын худалдах, худалдан авах гэрээний нийт үнийн дүнгийн “0.04” хувиас доошгүй байсныг СЗХ-ны 2023.08.11-ний өдрийн 399 дүгээр тогтоолоор 2024.07.01-ний өдрийг хүртэл хугацаанд угаасан ноолуурын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг “0.02” хувь, самнасан ноолуурын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг “0” хувиар тус тус тогтоосон. • “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг СЗХ-ны даргын 2023.11.16-ны өдрийн 483 дугаар тушаалаар батламжилсан. Тус журмын нэмэлт өөрчлөлтөөр хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгэх хөлсний хувь хэмжээг 50 хувиар бууруулан 0.25 хувь, жилийн үйлчилгээний хөлсний хувь хэмжээг 50 хувиар бууруулан 0.025 хувь болгон тус тус бууруулан тогтоосон. • “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-иас “Үнэт цаасны клирингийн журам”-ыг СЗХ-ны даргын 2023.12.18-ны өдрийн 545 дугаар тушаалаар батламжилсан. Тус журмын шинэчилсэн найруулгаар засгийн газар, аймаг, нийслэлийн өрийн хэрэгсэл гаргахад тооцогдох клирингийн үйлчилгээний шимтгэлийг бусад өрийн хэрэгсэл гаргагчийн шимтгэлээс 2 дахин багаар тогтоосон. • “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 46 дугаар тогтоолоор баталсан “Арилжааны журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг СЗХ-ны даргын 2023.12.21-ний өдрийн 558 тоот тушаалаар батламжилсан. Тус журмын нэмэлт, өөрчлөлтөөр “Монголын

						хөрөнгийн бирж" ХК-иар хийгдэх хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн шимтгэлийг арилжааны үнийн дүнгээс үл хамааран 0.3 хувиар тооцох, арилжааны шимтгэлийн хувь хэмжээг 25 хувиар бууруулан тогтоосон. 2/ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн спот болон форвард гэрээний арилжаанаас авах үйлчилгээний төлбөр, хураамжийн дээд хязгаарыг худалдан авагч талаас 0.5 хувиас ихгүй, худалдагч талаас 1 багц тутамд 200,000 төгрөгөөс ихгүй байхаар СЗХ-ны 2023 оны 793 дугаар тогтоолоор тогтоож, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6593 дугаарт бүртгэсэн. 3/ Даатгалын зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 30.2-т "Хороо даатгалын ангилал, хэлбэр, төрлөөс хамааран даатгагчаас даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тогтоож болно" гэж заасан бөгөөд энэхүү зохицуулалтын дагуу даатгалын зуучлагчид олгох шимтгэлийг илүү уян хатан, бүтээгдэхүүн үйлчилгээтэй уялдуулсан хэлбэрээр олгож, тогтоох боломж бүрдэнэ. Даатгалын багц хуулийн төсөлд санал авахаар Сангийн сайдын 2023.02.09-ний өдрийн 01/822 тоот албан бичгийг холбогдох яамд руу хүргүүлсэн. Үүний дагуу ирүүлсэн саналуудыг хуулийн төсөлд тусгах эсэх асуудлаар Сангийн яамтай хамтран ажилласан. Хуулийн төслийг Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлэх чиглэлээр судалж, холбогдох өөрчлөлтийг оруулж, эцэслэн боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулж, УИХ-д өргөн барихаар ажиллаж байна
		4.2.Компанийн өрийн хэрэгсэл гаргах зах зээлийн эрх зүйн орчныг сайжруулж,	4.2.1.Компанийн өрийн хэрэгслийг хувьцааны бүртгэлээс хөнгөвчилсөн байдлаар бүртгэхтэй	**Санхүүгийн зохицуулах хороо**	2020-2024	**<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** 1/ "Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам"-ыг СЗХ-ны 2020 оны 995 дугаар тогтоолоор батлан. Уг

		биржийн бус зах зээлийг хөгжүүлэх	холбоотой дүрэм, журам гаргаж, биржийн болон биржийн бус зах зээлээр дамжуулан арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх	- Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журмын төслийг боловсруулж, батлан, биржийн бус зах зээлийг бий болгож, хөгжүүлэх; - Компанийн өрийн хэрэгсэл гаргах, бүртгүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хувьцаанаас ялгаатай байдлаар буюу өрийн хэрэгслийн онцлогт тохирсон, илүү хөнгөвчилсөн байдлаар бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан тухайлсан журмын төслийг боловсруулж, батлах; - Үнэт цаасны бүртгэлийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, батлах; - Үнэт цаас гаргагчид аудит, хууль, үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч этгээдүүдийг чадавхжуулах чиглэлээр холбогдох бүртгэлийн журмуудыг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн өөрчлөлт оруулж, батлах;		журмаар "Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо" /МҮЦАЭХ/ биржийн бус зах зээлийг удирдан зохион байгуулах үүрэгтэй болсон бөгөөд МҮЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн хурлын 2021.06.29-ний өдрийн 8 дугаар тогтоолоор "Биржийн бус зах зээлийн ерөнхий журам", "Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам", "Биржийн бус зах зээлийн арилжааны багц журам"-уудыг баталсан. Биржийн бус зах зээлийн зохицуулалтын орчин бий болсноос хойш өрийн хэрэгслийн анхны арилжааг 2021 оны 9 дүгээр сард амжилттай эхлүүлсэн 2024.09.30-ны өдрийг хүртэлх хугацаанд биржийн бус зах зээлд нийт 125 үнэт цаас гаргагчийн 3.69 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 232 өрийн хэрэгсэл бүртгэгдсэнээс 2.89 их наяд төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна. Инновацын тухай хуулийн 121 дэх заалтын дагуу гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгон гаргахтай холбогдсон харилцааг "Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам"-д тусгаж, нэмэлт, өөрчлөлтийг СЗХ-ны 2021 оны 348 дугаар тогтоолоор баталсан. Мөн биржийн бус зах зээл дээрээс дотоодын аж ахуйн нэгжийн санхүүжилт татах сонирхлыг улам нэмэгдүүлж, үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулж, түүнтэй холбоотой гарах зардал, өртөг, хугацаа багасгах чиглэлийн хүрээнд СЗХ-ны зүгээс холбооны "Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны үнэт цаасны бүртгэлийн журам"-ын шинэчилсэн найруулгыг СЗХ-ны даргын 2023.01.11-ний өдрийн 17 дугаар тушаалаар батламжилсан. Уг журмын зохицуулалтын үр дүнд үнэт цаас гаргагчийн хаалттай өрийн хэрэгсэл гаргах ажиллагаа хялбар шуурхай болж, түүнд шаардагдах хугацаа багасах, зардал, өртөг буурах зэрэг эерэг нөлөөг биржийн бус зах зээлд бий болгох давуу талыг бүрдүүлсэн.

						2/ "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-д компанийн бонд гаргахад СЗХ болон арилжаа эрхлэх байгууллагад хийгддэг хяналтын ажиллагааны давхардлыг арилгах, бүртгэлийн үйл ажиллагааны хугацааг багасгах, нэг удаа СЗХ-нд бүртгүүлсэн өрийн хэрэгслийг хэсэгчлэн, үе шаттайгаар нийтэд санал болгох зэрэг зохицуулалтыг тусгасан. Мөн ногоон бондын зохицуулалтыг нэмж тусгаж, СЗХ-ны 2021.06.11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021.06.25-ны өдрийн 5334 дугаарт бүртгүүлсэн. УИХ-аас 2021 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Өрийн удирдлагын тухай хуульд аймаг, нийслэлийн Засаг даргаас нийтэд санал болгон үнэт цаас гаргахтай холбоотой зохицуулалтыг нэмж тусгасан тул СЗХ-ны 2022 оны 68 дугаар тогтоолоор "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-д тусгах аймаг, нийслэлийн Засаг даргаас нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой зохицуулалтын нэмэлт, өөрчлөлтийг баталж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021.06.25-ны өдрийн 5334 дугаарт бүртгүүлсэн.
		4.3.Үндэсний хөгжилд шаардлагатай төсөл хөтөлбөрийг тэтгэвр ийн сан, үндэсний хуримтлалын сан зэрэг нийтийн өмчлөл бүхий сангаас хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлдэг байх	4.3.1.Сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулах агуулгаар сангийн эрх зүйн байдал, харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх	**Засгийн газар**	2020-2024	**<u>Засгийн газар</u>** Гадаадын хөрөнгө оруулагчид дотоодын хөрөнгө оруулагчидтай ижил нөхцөлөөр буюу Монголын үнэт цаасны зах зээлээс худалдан авсан үнэт цаасаа борлуулахад анх худалдаж авсан дүн болон шимтгэлийн зардлаа хасаж, ашгаас татвараа тооцно; Засгийн газар, аймаг, нийслэл, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн дотоодын үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлнө;

		эрх зүйн орчныг бий болгох				Хөрөнгийн биржийн арилжаанд оролцогчид тус бүр татвараа өөрөө тооцож тайлагнадаг байх тогтолцоог өөрчилж төр өөрт байгаа арилжааны мэдээлэлд үндэслэн татвар төлөгчдөд хүндрэлгүй нэгдсэн журмаар татварыг суутган тооцох системийг нэвтрүүлэх зэрэг болно. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.
				Санхүүгийн зохицуулах хороо Нийтийн өмчлөл бүхий сангийн хөрөнгө оруулалтын олон улсын туршлагыг судалж, дүгнэлт гарган холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал боловсруулах		**Санхүүгийн зохицуулах хороо** 1/ СЗХ-ны дарга, Сангийн сайдын 2020.09.30-ны өдрийн 329/187 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хуульд дараах зарчмын хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах судалгаа, дүгнэлт, санал бүхий нэгтгэсэн тайланг боловсруулж Сангийн яаманд СЗХ-ны 2021.03.16-ны өдрийн 1/964 тоот, УИХ-ын ЭЗБХ-нд 2021.03.31-ний өдрийн 1/1222 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. Үүнд: 1.Тусгай сангуудын сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зориулалттайгаар Засгийн газрын баталгаатай, Хөгжлийн банкны гаргасан болон тус байгууллагын баталгаатай дотоодын зах зээлд гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэх; 2.Тусгай чиглэл, үүрэгтэй сангуудаас олгох санхүүжилтийг зөвхөн банкны зээлээр дамжуулан санхүүжүүлэхгүй, хөрөнгийн зах зээл дээр тухайн чиглэлийн хуулийн этгээдийн гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулах хэлбэрээр санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх; 3.Ирээдүйн өв сан гэх мэт хуримтлалын сангуудыг дотоодын зах зээлд Засгийн газрын нэгдэн орсон олон


						улсын санхүүгийн байгууллагаас гаргасан, эсхүл тус байгууллагын баталгаатайгаар гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэх. 2/ Даатгалын компаниудын үндсэн үйл ажиллагааны нэг болох хөрөнгө оруулалтын удирдлагыг зөв зохистой, оновчтой хэлбэрээр хэрэгжүүлж олон улсын жишигт нийцүүлэх, хөрөнгийн зах зээлийг дэмжих, даатгагчийн хөрөнгийг олон талт хөрөнгө оруулалтад байршуулах, эрсдэлийг тархаах зорилгоор СЗХ-ны холбогдох журмуудад өөрчлөлт оруулж СЗХ-ны 2021.02.24-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор батлаж Захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлсэн. 3/ Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд 2024.04.01-ний өдөр холбогдох саналыг хүргүүлсэн. Тус хуулийн төсөлд нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан тодорхой санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах холбогдох зохицуулалтыг тусгасан байна..
		4.4.Банк хөрөнгийн зах зээлд оролцох зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн зээлийн бус хэлбэрээр санхүүжилт олгох нөхцөл бүрдүүлэх	4.4.1.Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, уламжлах	**Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо** УИХ-ын гишүүн Б.Баттөмөрийн УИХ-д өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгч хууль тогтоогчтой хамтран ажиллах, холбогдох дүрэм, журмын төслийг хамтран боловсруулан батлах.	2020-2024	**<u>Монголбанк, СЗХ</u>** Биелсэн (100%) УИХ-ын гишүүн Б.Баттөмөрийн УИХ-д өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах чиг үүрэг бүхий УИХ-ын гишүүн Г.Амартүвшингээр ахлуулсан ажлын хэсгийн дэд ажлын хэсэгт ажиллаж Банкны тухай хуульд нэмэйт, өөрчлөлт оруулах тухай хууль 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр батлагдаж 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. **<u>Санхүүгийн зохицуулах хороо</u>** 1/ Банкны салбарын реформын хүрээнд дээрх системийн банкнууд хөрөнгийн зах зээл дээр IPO хийх замаар нээлттэй хувьцаат компани болох ажиллагаа

						хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох зорилгоор СЗХ Монголбанктай хамтран холбогдох нэр бүхий журмуудыг баталсан. 2/ СЗХ-ноос банкнууд хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчаар оролцох боломжийг хязгаарласан Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийг "Энэ хуулийн 17.5-д зааснаас бусад тохиолдолд банкны худалдан авах дотоодын үнэт цаасны зах зээлд гаргасан компанийн өрийн хэрэгслээс бусад үнэт цаасны нийт дүнь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд нэг компани, түүний нэгдлийн оролцогчийн гаргасан хувьцааны 10 хувиас дээшгүй байна. Үүнд Засгийн газар, Төв банкны үнэт цаас, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн хувьцаа хамаарахгүй." гэж өөрчлөн найруулах саналыг СЗХ-ны 2021.03.12-ны өдрийн 1/853 тоот албан бичгээр Монголбанканд, мөн өдрийн 1/854 тоот албан бичгээр УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнд, 1/855 тоот албан бичгээр УИХ-ын гишүүн С.Чинзоригт тус тус хүргүүлсэн. 3/ Монголбанкны Ерөнхийлөгч, СЗХ-ны даргын 2022.12.02-ны өдрийн А-336, 512 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан "Хувьцаат компани хэлбэртэй банкны хяналт шалгалтын хууль тогтоомжийн нийцэл, давхардлыг судлан, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг"-т Үнэт цаасны газрын холбогдох төлөөллүүд орж ажилласан. 4/ УИХ-ын чуулганы 2023.01.20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль баталсан. Тус хуулиар хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах, зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрхлэх үйл ажиллагааны хүрээ, удирдлага, зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулсан. Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулсан Хөрөнгө

						оруулалтын төрөлжсөн банкны тухай хуульд нийцүүлж хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл олгох, үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хязгаарлалт, зохистой харьцаа, хяналт шалгалттай холбоотой журам боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт СЗХ-ны төлөөлөл ажиллаж Монголбанктай хамтрах батлахаар заасан нэр бүхий журмын төслүүд болох "Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны худалдах, худалдан авах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, хэмжээг тогтоох, хэлцэл хийхэд баримтлах журам", "Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журам", "Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам" болон Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас олгох зээлд баримтлах шаардлагыг боловсруулж СЗХ-ны 2023.08.11-ний өдрийн хуралдаанд танилцуулсан ба Монголбанкны Ерөнхийлөгч, СЗХ-ны даргын 2023.08.29-ний өдрийн А-164/386, А-165/385 дугаар хамтарсан тушаалаар тус тус баталсан.

ХҮҮ


Зээлийн хүү, хадгаламжийн хүүний зөрүү



Шинээр олгогдсон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) суурь оны түвшнээс **0.2** нэгж хувиар, шинээр татсан төгрөгийн хадгаламжийн ЖДХ **1.0** нэгж хувиар өсжээ.
Шинээр татсан төгрөгийн хадгаламж болон шинээр олгосон төгрөгийн зээлийн хүүний зөрүү суурь оны түвшнээс **0.8** нэгж хувиар буурч **5.5** нэгж хувьд хүрэв.

Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү*, хугацаатай хадгаламжийн хүү
(**хөнгөлөлттэй хүүтэй зээл оруулснаар*)



Хөнгөлөлттэй зээлийг оруулж тооцсон шинээр олгогдсон төгрөгийн зээлийн ЖДХ суурь оны түвшинтэй харьцуулахад **0.2** нэгж хувиар, нийт шинээр татсан төгрөгийн хугацаатай хадгаламжийн ЖДХ **0.8** нэгж хувиар өссөн байна.
Шинээр татсан төгрөгийн хугацаатай хадгаламж болон шинээр олгосон төгрөгийн зээлийн хүүний* зөрүү **5.0** нэгж хувь болж суурь оны түвшинтэй харьцуулахад **0.6** нэгж хувиар буурав.

Эх сурвалж: Монголбанк


278

Зээлийн хүүний өөрчлөлт (2019.12-2024.09)

	2019.12*	2020.12	2021.12	2022.12	2023.12	2024.09	Өөрчлөлт**
Нийт олгосон зээлийн хүү	16.9	14.8	14.3	15.7	16.7	17.1	0.2
Иргэд	18.5	15.8	14.5	16.1	17.2	17.4	-1.1
Хувийн байгууллага	15.7	15.3	14.2	15.6	16.3	16.6	0.9
Нийт олгосон зээлийн хүү (Хөнгөлөлттэй зээл орсоноор)	16.6	14.4	13.2	15.2	16.0	16.8	0.2
Иргэд	15.7	15.3	14.1	15.4	16.2	16.9	1.2
Хувийн байгууллага	18.5	15.8	10.8	15.1	15.7	16.6	-1.9

* - Суурь түвшин буюу 2019 оны жилийн эцсийн ЖДХ (УИХ-ын 21-р тогтоол, 2020.08.28)
**- Суурь түвшинтэй харьцуулсан зөрүү

Хүүний харьцуулалт (төгрөг)



Зээлийн хүүг бууруулах УИХ-ын 2020.08.28-ны өдрийн 21 дугаар тогтоолд тусгагдсаны дагуу 2019 оны зээлийн хүүний түвшинг суурь түвшин болгож хамгийн сүүлийн статистиктай (2024.09 сард) харьцуулахад төгрөгөөр олгосон нийт зээлийн ЖДХ **0.2** нэгж хувь, хувийн байгууллагынх **0.9** нэгж хувиар өссөн бол, иргэдийнх **1.1** нэгж хувиар буурсан байна. Гадаад валютын зээлийн хүү **10.9** хувь болж суурь оны түвшинтэй харьцуулахад **2.2** нэгж хувиар өсжээ.

Зээлийн хүүг бууруулах стратеги батлагдсан 2020.08 сард бодлогын хүү 9.0 хувь, суурь он (2019)-ы түвшинд **11.0** хувьтай байсан бол 2024.09.30-ний өдрийн байдлаар **10.0** (*өөрчлөгдсөн огноо: 2024.09.16*) хувь байна.
Төгрөгийн хадгаламжийн ЖДХ бодлогын хүүнээс **1.5** нэгжээр их байгаа бол хугацаатай хадгаламжийн хүү суурь оны түвшинтэй харьцуулахад 0.8 нэгж хувиар өсөж **11.7** хувьд хүрчээ (2024.09 сар).

Хувийн байгууллагын зээлийн хүүний* өөрчлөлт (салбараар)
*(*хөнгөлөлттэй хүүтэй зээл оруулснаар)*

Салбарын ангилал	Тайлант сард олгосон төгрөгийн зээлийн ЖДХ (%)						Өөрчлөлт
	2019.12	2020.12	2021.12	2022.12	2023.12	2024.09	2019.12 2024.09
НИЙТ	**15.7**	**15.3**	**12.4**	**15.1**	**15.7**	**16.6**	**0.8**
ХАА	15.6	3.6	10.2	11.4	11.0	14.7	-0.9
Уул уурхай	11.9	14.2	15.5	15.9	16.9	17.1	5.2
Боловсруулах	12.6	15.8	10.7	12.1	12.9	15.8	3.2
Барилга	15.9	17.2	14.7	17.8	17.3	17.9	2.0
Худалдаа	16.2	14.9	11.9	15.0	15.4	16.2	0.0
Тээвэр агуулах	17.3	16.9	15.4	18.3	19.1	17.5	0.3
Зочид буудал	16.5	14.6	10.6	16.6	14.2	18.0	1.5
Үйлчилгээний бусад	-	13.2	11.5	18.2	17.4	16.4	-
Санхүү даатгал	19.2	14.4	17.9	16.2	18.0	15.7	-3.5
Үл хөдлөх	17.1	17.5	14.7	18.0	14.9	17.5	0.4

Тайлант сард хувийн байгууллагад олгосон зээлийн хүү суурь онтой харьцуулахад санхүү даатгал 3.5, ХАА 0.9 нэгж хувиар тус тус буурсан байна.

Иргэдийн зээлийн хүүний* өөрчлөлт (салбараар)
*(*хөнгөлөлттэй хүүтэй зээл оруулснаар)*

Салбарын ангилал	Тайлант сард олгосон төгрөгийн зээлийн ЖДХ (%)						Өөрчлөлт
	2019.12	2020.12	2021.12	2022.12	2023.12	2024.09	2019.12 2024.09
НИЙТ	**18.5**	**15.8**	**13.7**	**15.4**	**16.2**	**16.9**	**-1.6**
ХАА	20.7	6.1	15.2	17.7	15.5	8.2	-12.5
Уул уурхай	16.1	15.3	13.1	10.2	11.7	13.8	-2.4
Боловсруулах	19.7	17.1	15.1	20.4	20.1	19.9	0.2
Барилга	19.0	5.1	15.8	20.0	20.5	18.0	-1.0
Худалдаа	19.2	17.1	15.9	19.4	19.4	19.4	0.1
Тээвэр агуулах	20.9	19.0	17.3	21.6	19.5	21.4	0.5
Зочид буудал	21.6	19.7	13.8	19.7	21.2	19.8	-1.8
Үйлчилгээний бусад	-	17.5	14.6	19.4	19.7	18.0	-
Санхүү даатгал	20.1	18.0	12.4	22.4	18.8	23.9	3.8
Үл хөдлөх	10.7	8.4	9.6	10.2	10.3	13.0	2.4
Хэрэглээний зээл	17.1	17.2	13.9	16.0	16.9	17.2	0.2
Цалин	*17.9*	*16.0*	*14.4*	*16.8*	*17.7*	*17.6*	*-0.3*
Тэтгэвэр	*13.4*	*15.6*	*14.4*	*15.6*	*15.8*	*15.8*	*2.3*
Автомашин	*19.9*	*18.9*	*15.8*	*18.4*	*19.8*	*18.6*	*-1.2*
Өрхийн хэрэглээ	-	*20.9*	*18.4*	*20.3*	*21.4*	*22.2*	-
Мөлчны	-	*19.5*	*17.3*	*20.9*	*20.9*	*21.0*	-
Хадгаламж барьцаалсан	*18.3*	*17.5*	*14.4*	*15.8*	*17.2*	*17.6*	*-0.7*

Суурь онтой харьцуулахад хэрэглээний зээл (2024.09-р сарын байдлаар иргэдийн нийт зээлийн үлдэгдлийн 53.7%)-ийн хүү 0.2 нэгж хувиар өссөн байна. Иргэдийн автомашины зээлийн хүү 1.2, хадгаламж барьцаалсан зээлийн хүү 0.7, цалингийн зээлийн хүү 0.3 нэгж хувиар тус тус буурчээ.